



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ



ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА 2015

2012-2013 оны хичээлийн жилд
төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх
судалгаа 2015

Улаанбаатар хот

ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР

ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА-2015

2012-2013 оны хичээлийн жилд төгсөгчдийн
хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа

Улаанбаатар хот

“Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” –г 2014 онд хийсэн бөгөөд судалгаанд 2012-2013 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн 2000 төгсөгч хамрагдсан. Энэ удаагийн судалгаа нь 2014 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийг 2015 онд дахин судалгаанд хамруулж мөшгөн судалснаараа онцлог юм.”

Тайланг хянасан:

ХЭҮСМҮТ-ийн ХССМГ-ын дэргэдэх Бодлого, арга зүйн зөвлөл

Хэвлэлд бэлтгэсэн:

Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газрын мэргэжилтэн
Д.Алтангэрэл

Мэдээллийг боловсруулсан:

Хөдөлмөрийн судалгаа, сургалт мэдээллийн газрын мэргэжилтэн
Д.Алтангэрэл

Хэвлэсэн тоо: 300 хувь

Цаасны хэмжээ: B5

“Хөх Монгол принтинг” ХХК-д хэвлэв.

Улаанбаатар 2016 он

ГАРЧИГ

| | |
|--|----|
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ | 4 |
| ЗУРГИЙН ЖАГСААЛТ | 5 |
| ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ | 6 |
| ӨМНӨХ ҮГ..... | 7 |
| СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ | 8 |
| БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА | |
| 1.1. Судалгааны зорилго, зорилт | 16 |
| 1.2. Судалгаанд хамрагдсан байдал | 16 |
| БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ | |
| 2.1 Хөдөлмөр эрхлээгүй төгсөгчид | 23 |
| 2.2 Хөдөлмөр эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны төлөв, байдал, онцлог ... | 25 |
| 2.3 Давхар хөдөлмөр эрхлэлт | 37 |
| БҮЛЭГ 3. СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД СУРГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙДАЛ | |
| 3.1 Дахин суралцагсад | 43 |
| БҮЛЭГ 4. АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ, ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ | |
| 4.1 Ажил хайх зорилго, шалтгаан | 46 |
| 4.2 Ажил хайх хэлбэр, хичээл зүтгэл | 47 |
| 4.3 Цаашдын төлөвлөгөө | 49 |
| ДҮГНЭЛТ | 52 |
| ХАВСРАЛТ | 55 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо, хамрагдсан хувь | 17 |
| Хүснэгт 2. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал 2014, 2015 он /мэргэжлийн чигллээр/ | 21 |
| Хүснэгт 3. MCYT төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал 2014, 2015 он /мэргэжлийн чиглэлээр/ | 22 |
| Хүснэгт 4. Ажил хийдэг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, 2014, 2015 он | 27 |
| Хүснэгт 5. Ажил хийдэг төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын өдөр, цагаар 2014, 2015 он /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/ | 29 |
| Хүснэгт 6. Ажил хийдэг төгсөгчдийн сарын дундаж ажил, амралтын өдөр, цалингийн хэмжээ 2014, 2015 он /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/ | 30 |
| Хүснэгт 7. Ажлын байрны сэтгэл ханамж 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 30 |
| Хүснэгт 8. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 31 |
| Хүснэгт 9. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 31 |
| Хүснэгт 10. Ажлын байран дахь ур чадварын хомсдол 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 32 |
| Хүснэгт 11. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 33 |
| Хүснэгт 12. Ажилд ороход нөлөөлдөг хүчин зүйлс 2014, 2015 он /сургуулийн төрөл/ | 33 |
| Хүснэгт 13. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал 2014, 2015 он /сургуулийн төрлөөр/ | 34 |
| Хүснэгт 14. Давхар ажил эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрлөөр/ | 38 |
| Хүснэгт 15. Давхар ажил эрхэлдэг төгсөгчдийн ажлын цаг, цалин орлого /сургуулийн төрлөөр/ | 38 |
| Хүснэгт 16. Суралцсан сургалтын төрөл, сургуулийн төрлөөр | 42 |
| Хүснэгт 17. Суралцаж байгаа мэргэжил болон өмнөх мэргэжлийн нийцэл | 44 |
| Хүснэгт 18. Ажлын байрны сонголт хийхэд чухалчилдаг зүйлс /сургуулийн төрлөөр/ | 47 |
| Хүснэгт 19. Ажил хайх явцад гардаг хүндэрлэг бэрхшээл /сургуулийн төрлөөр/ | 48 |
| Хүснэгт 20. Төгсөгчдийн ажиллахыг хүсч буй байгууллагын хэлбэр /сургуулийн төрлөөр/ | 49 |
| Хүснэгт 21. Ажиллахыг хүсч буй байгууллага болон сонгосон шалтгаан /сургуулийн төрлөөр/ | 50 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Зураг 1. Ажил хийдэг төгсөгчдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд дахь хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөн | 11 |
| Зураг 2. 2014 – 2015 онд гарсан хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт | 20 |
| Зураг 3. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид, төгссөн сургуулийн байршил буюу бүсээр, 2014, 2015 он | 21 |
| Зураг 4. 2014 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн 2015 оны хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, сургуулийн төрлөөр | 23 |
| Зураг 5. 2015 онд ажилгүй байгаа боловч 2014 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн ажлаас гарсан шалтгаан /сургуулийн төрлөөр/..... | 24 |
| Зураг 6. 2015 онд ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгаан, хувиар..... | 24 |
| Зураг 7. 2014 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн ажил хайхгүй байгаа шалтгаан | 25 |
| Зураг 8. Ажил хийж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/ | 26 |
| Зураг 9. Ажил хийж байгаа төгсөгчдийн ААНБ-ын ажилтны тоо 2014, 2015 он..... | 27 |
| Зураг 10. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаан /сургуулийн төрлөөр/..... | 28 |
| Зураг 11. Хөдөлмерийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид сургуулийн төрөл, өмчийн хэлбэр, 2014, 2015 оны байдлаар | 28 |
| Зураг 12. Ажил хийдэг төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр 2014, 2015 он..... | 29 |
| Зураг 13. Ажил хийдэг төгсөгчдийн ажил мэргэжлийн ангиал /сургуулийн төрлөөр/..... | 35 |
| Зураг 14. Ажил хийдэг төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллах шалтгаан /сургуулийн төрөл/ | 36 |
| Зураг 15. Ажил хийдэг төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллахгүй шалтгаан /сургуулийн төрөл/..... | 36 |
| Зураг 16. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж /сургуулийн төрлөөр/..... | 37 |
| Зураг 17. Давхар ажил хийж буй шалтгаан /сургуулийн төрлөөр/ | 39 |
| Зураг 18. Сургалтын төлбөр төлсөн байдал /сургуулийн төрлөөр/ | 43 |
| Зураг 19. Дахин суралцаж байгаа шалтгаан | 43 |
| Зураг 20. Сургалтанд хамрагдсаны дараах өөрчлөлт /сургуулийн төрөл/..... | 44 |
| Зураг 21. Ажил хайж байгаа төгсөгч /сургуулийн төрлөөр/ | 46 |
| Зураг 22. Ажилгүй байгаа төгсөгчдийн сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн бус байсан шалтгаан | 46 |
| Зураг 23. Ажил хайх хэлбэр 2014, 2015 он /сургуулийн төрлөөр/ | 47 |
| Зураг 24. Ажил хайх хичээл, зүтгэл 2014, 2015 он..... | 48 |
| Зураг 25. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /сургуулийн төрлөөр/..... | 49 |
| Зураг 26. Төгсөгчдийн ажиллахыг хүсч буй байгууллага болон цалингийн хэмжээ /сургуулийн төрлөөр/..... | 51 |

ХАВСРАЛТ

| | |
|--|----|
| Хавсралт 1. Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл ба ажиллаж буй эдийн засгийн салбар, хувиар | 56 |
| Хавсралт 2. Ажил үүрэг эзэмшсэн мэргэжлийн нийцэл, мэргэжлийн чиглэлээр | 58 |
| Хавсралт 3. MCYT төгсөгчдийн дахин суралцаж буй мэргэжил, сонгосон шалтгаан | 60 |
| Хавсралт 4. ИДС төгсөгдийн дахин суралцаж буй мэргэжил, сонгосон шалтгаан, магистр ба докторын зэргээр..... | 62 |
| Хавсралт 5. ИДС төгсөгчдийн дахин суралцаж буй мэргэжил, сонгосон шалтгаан, бакалаврын зэргээр..... | 65 |

ӨМНӨХ ҮГ

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь үндэсний хэмжээнд төлөөлөх чадвар бүхий томоохон хэмжээний түүвэр судалгаа билээ. Энэ удаагийн судалгаанд 2012/2013 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгчдийг хоёр дахь жилдээ хамруулсан.

Бодлого боловсруулагчид болон судлаачдыг хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах суурь тоо мэдээллээр хангах, түүнчлэн төгссөний дараа ажлын байраар хангагдахгүй байгаа асуудлыг гүнзгийрүүлэн судлахад судалгааны зорилго чиглэгдсэн ба төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь хөдөлмөрийн зах зээл дэх залуучуудын төлөв байдал, ажлын туршлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллээр хангах бөгөөд сургууль төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл рүү шилжиж байгаа үйл явцын талаарх мэдээллийг агуулсан болно.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг ажил мэргэжлийн түвшинд судлах явдал нь бодлого боловсруулахад ихээхэн ач холбогдолтой. Зах зээлд бэлэн байгаа ажлын байрны шаардлагад сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа шинэ мэргэжилтэй ажилтнууд нийцэж чадаж байгаа эсэх асуудал нь үүнтэй холбоотой нэгэн багц судлагдахуун юм. Мөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, хөдөлмөр эрхлэлтийн талаарх хэтийн төлөвлөгөө зэрэг асуудлыг тоон болон чанарын үзүүлэлтүүдээр дамжуулан судалж тодорхойлохыг зорилоо.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандaa ашиглаж судалгааны үр дүн, арга зүйтэй холбоотой санал, зөвлөмжийг, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ С.ЧОЙНОРОВ

СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

Судалгааны зорилго нь 2014 онд хийсэн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-нд хамрагдсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг судалж дүн шинжилгээ хийхэд оршино. Энэ удаагийн судалгаанд төгсөгчдийн боловсрол, гэр бүлийн амьдралд гарсан өөрчлөлт, нэг жилийн өмнө болон одоо хийж байгаа ажилтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, дахин суралцсан эсэх, ажил хайж байгаа болон ажилгүй байгаа төгсөгчдийн цаашдын зорилгыг тусгасан.

Судалгаанд 1719 төгсөг хамрагдсан ба ИДС төгсөгч 1151, MCYT төгсөгч 568 байна. Өмнөх оны судалгаанд хамрагдсан төгсөгчидтэй харьцуулахад 14 хувиар буурсан. Төгсөгчдийн хаяг, утасны дугаар өөрчлөгдэж холбоо тогтоох боломжгүй болсон, гадаад явсан, судалгаа өгөхөөс татгалзсаны улмаас зорилтот түүврийн хэмжээ буурсан болно.

Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 43.9 хувь нь эрэгтэй, 56.1 хувь нь эмэгтэй байсан ба, магистрын зэрэгтэй ИДС төгсөгчид 1.5 хувиар нэмэгдсэн. Мөн гэрлэлт өмнөх оныхоос 8.1 хувиар өссөн, өрхийн орлого 751,000-1,000,000 төгрөг байдаг бүлэг хамгийн их байна.

Судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн 66.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа ба өмнөх оныхоос 2.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт эрэгтэй төгсөгчдийн 75.7 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 59.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. 2014 онд ажилгүй байсан төгсөгчдийн 35.0 хувь нь, ажилтай байсан төгсөгчдийн 84.7 хувь нь 2015 онд хөдөлмөр эрхэлж байна.

Эзэмшсэн мэргэжлээрээ ИДС төгсөгчдийн хувьд сурган хүмүүжүүлэх ухаан, цэрэг, цагдаа, аюулгүй байдал зэрэг мэргэжлийн чиглэлүүд 80-аас дээш хувийн хөдөлмөр эрхлэлтээ хадгалж байна. Харин бизнес ба мэдээлэл, биологи, үйлдвэрлэлийн технологи, мал эмнэлэг, нийгмийн хalamж хангамжийн чиглэлийн мэргэжлүүд 70-аас доош хувийн хөдөлмөр эрхлэлттэй байсаар байна. 2015 онд судалгаанд анагаах ухаан болон компьютерийн мэргэжлийн чиглэлийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурч 70-аас доош хувь болсон байна.

MCYT төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оныхоос 20 гаруй хувиар өссөн байна. 2015 онд хамгийн бага хөдөлмөр эрхлэлттэй буюу өмнөх оны хөдөлмөр эрхлэлтээс буурсан үзүүлэлттэй байгаа нь холбооны салбарын мэргэжлүүд байна.

2014 онд ажилгүй байсан их дээд сургууль төгсөгчдийн 61.8 хувь нь 2015 онд ч ажилгүй, 3.3 хувь нь сурч байгаа, 35.0 хувь нь ажил хийдэг болсон байна. MCYT төгссөн 2014 онд ажилгүй байсан төгсөгчдийн 60.7 хувь нь 2015 онд ажилгүй байгаа ба 4.7 хувь нь сурдаг, 34.5 хувь нь л ажил хийж байна.

Ажилгүй байгаа төгсөгчдөөс ажил хайж байгаа эсэхийг тодруулахад тэдний 32.9 хувь нь ажил хайж байгаа үлдсэн 67.1 хувь нь ажил хайхгүй байна. Ажил хайхгүй төгсөгчдөөс шалтгааныг асуухад 47.4 хувь нь хүүхэд, өндөр настан асрах, 30.7 хувь нь сургуульд суралцсан гэж хариулсан.

Одоогийн ажлын байрандаа хэдэн жил ажиллаж байгааг тодруулахад ИДС төгсөгч дунджаар 1.2 жил, MCYT төгсөгч дунджаар 1 жил ажилласан байна. Нийт төгсөгчдийн 82.1 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байна. Улирлын чанартай

ажлын байранд ажиллагчдын тоо хэмжээ нийт ажил хийж буй төгсөгчдийн 11.5 хувь байгаа бол, 5.4 хувьтай тэнцэх нь түр, 0.9 хувь нь цагийн ажил эрхэлж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь өмнөх оны судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 77.4 хувь нь нийгмийн даатгал төлдөг. Энэ дүн их дээд сургууль төгсөгчдийн хувьд 81.3 хувь, MCYT төгсөгчдийн хувьд 88.8 хувь байна. Үүнээс сайн дурын даатгал төлдөг ИДС төгсөгч 7.7 хувь, MCYT төгсөгч 5.4 хувь байна. Ажил хийж байгаа төгсөгчдөөс эрүүл мэндийн даатгал төлдөг эсэхийг асуухад нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 91.3 хувь нь төлдөг гэж хариулсан ба ИДС төгсөгчийн 90.2 хувь, MCYT төгсөгчийн 93.1 хувь нь эрүүл мэндийн даатгал төлдөг гэж тус хариулсан. Мөн хувь хүний орлогын албан татвар төлдөг эсэхийг лавлахад ИДС төгсөгчийн 82.6 хувь, MCYT төгсөгчийн 88.1 хувь нь төлдөг гэж хариулсан.

Нийт ажил хийдэг төгсөгчдийн 31.0 /2014 оны судалгаанд 34.0 хувь байсан/ хувь нь 11-50 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй нь хамгийн олон байлаа. Мөн 23.9 хувь нь 10 хүртэл ажилтантай, 12.7 хувь нь 51-100 ажилтантай, 19.3 хувь нь 251-аас дээш ажилтантай, үлдсэн 13.0 хувь нь 101-250 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилласан тархалтыг харуулжээ. Ажил хийж байгаа төгсөгчид 100 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллах нь нэмэгдсэн нь зерэг үзүүлэлт харагдаж байна. ИДС төгсөгчдийн 56.8 хувь нь 50 хүртэлх ажилтантай жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байхад, MCYT төгсөгчдийн тухайд 52.2 хувь байна.

2015 онд ажил хийж байгаа төгсөгчдийн 95.4 хувь нь цалин хөлстэй ажилтны статусаар хөдөлмөр эрхлэгч байсан бол, тэдний 79.6 хувь нь байнгын ажилтан, 5.7 хувь нь түр ажилтан, 10.1 хувь нь улирлын чанартай ажилтан гэсэн үр дүнг үзүүлжээ. Харин хөдөлмөр эрхлэлтийн бусад статусын хувьд ажил олгогчийн статусаар хөдөлмөр эрхлэгч 0.6 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3.7 хувь, өрхийн бизнест оролцогч 0.3 хувь байна. MCYT төгсөгчдийн 1.9 хувь нь цалин хөлстэй ажилтны статус руу шилжилт хийсэн байна. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 25.6 хувь нь өөрсдийгөө цалинтай ажилтнаас илүү орлого олдог гэж үзэж байна.

Цалин хөлстэй ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид 10.0 хувиар өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад MCYT төгсөгчдийн хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах нь 31.7 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг болох хөдөлмөрийн гэрээтэй MCYT төгсөгчдийн тоо өсөж байгаа нь зерэг үр дүн харагдаж байна.

Төгсөгчдийн ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын төрлийг судлан үзэхэд хамгийн олноороо ажилладаг нь дотоодын хөрөнгө оруулалттай компани, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага төдийгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын өдрийн хувьд өөрчлөлт бага байна. Харин 7 хоногийн дундаж ажлын цаг 1.5 цагаар багассан байна. MCYT төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын цаг 5.8 цагаар багассан байгаа нь зерэг үр дүнг харуулж байна. 7 хоногийн нэмэлт ажлын цагийн хувьд 1.1 цагаар өсчээ. Харин хувийн өмчийн сургууль төгсөгчдийн нэмэлт ажлын цаг 2.8 цагаар нэмэгдсэн байна.

Төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ 1 жилийн өмнөх үеэс 98.2 мянган төгрөгөөр өссөн байна. MCYT төгсөгчдийн цалин 159.8 мянган төгрөгөөр өссөн нь хамгийн их ба үүний дараа хувийн өмчийн сургууль төгсөгчдийн цалин

149.1 мянган төгрөгөөр, төрийн өмчийн сургууль төгсөгч 48.1 мянган төгрөгөөр, ИДС төгсөгчийн цалин 35.7 мянган төгрөгөөр хамгийн бага нэмэгдсэн байна.


2015 онд төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ нь 708.2 мянган төгрөг байгаа бол ХЭҮСМҮТ-ийн “Цалин хөлсний бүтцийн судалгаа-2015”-гаар ААНБ-ын ажиллагчдын улсын дундаж 705.2 мянган төгрөг байна. Үүнээс харахад төгсөгчдийн дундаж цалин, цалин хөлсний бүтцийн судалгааны улсын дундажтай харьцуулахад зөвүү бага байна.

Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийн түвшин өмнөх оны судалгаатай ижил түвшинд байна. Байгууллагын нэр хүндийн сэтгэл ханамж ердийнөөс хангалуун болсон байна. Харин ажил, амралтын цагийн талаар сэтгэл ханамжийн түвшин өөрчлөгдөөгүй байна. Ер нь ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин ердийн буюу хангалуун гэсэн түвшинд хүрэхгүй байна. 2015 онд төгсөгчдийн ажлын байрны хамгийн сэтгэл ханамжтай байдаг үзүүлэлт нь байгууллагын нэр хүнд байна. Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг ба боловсролын түвшингийн тохиromжтой байдал өмнөх оноос 7.3 хувиар буурч 68.6 хувь болсон байна. Үүнээс үзэхэд боловсролоос хамаарсан ажил үүргийн үл нийцэл байна.

Өмнөх оны судалгаанд хамгийн олноор нэрлэсэн ур чадварын хомсдол болох гадаад хэлний мэдлэг, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал, багаар ажиллах чадварууд энэ онд ч байсаар л байна. Харин бусадтайгаа харьцуулахад шинжлэх ухаан, технологийн ур чадварын хомсдол 4.5 хувиар буурсан бол гадаад хэлний мэдлэгийн ур чадварын хомсдол 8.7 хувиар өссөн байна. МСҮТ төгсөгчдийн хувьд хамгийн ихээр дутагдаж байгаа ур чадвар нь гадаад хэлээр харилцах, мэдээллийн технологийг ашиглаж эзэмших байсан бол, ИДС төгсөгчдийн хувьд гадаад хэлний мэдлэг, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал, багаар ажиллах чадварууд байна. Цаашид дараа дараагийн төгсөгчдөд эдгээр дутагдалтай байгаа ур чадвар, мэдлэгийг хичээлийн хөтөлбөрт илүү тусгаж өгөх, хэвшил болгон хэрэглэж сурхад нь анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Хөдөлмөрийн зах зээлд шаардагдаж байгаа эдгээр ур чадварыг эзэмшигүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Сургууль төгсөөд 2.5-3 жилийн дараа 42.2 хувь нь ажлын байранд дасан зохицоход ямар нэг хүндрэл бэрхшээл тулгардаггүй гэж хариулсан байна. Энэ нь нэг жилийн өмнөх үзүүлэлтээс 19.8 хувиар буурсан бөгөөд төгсөөд удах тусам ажлын байранд дасан зохицоход тулгардаг хүндрэл бэрхшээл нь багасч байна. Төгсөгчдийн 12.5 хувь нь ажлын хэв маягт дасан зохицох байдал мөн адил 12.5 хувь нь ажлын туршлага дутах гэж хариулсан ба хамгийн ихээр тулгардаг бэрхшээлүүд байна. Ажилд ороход хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйлүүд нь эзэмшсэн мэргэжил, төгссөн сургууль, хувийн зан чанар байна.

Зураг 1. Ажил хийдэг төгсөгчдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарууд дахь хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөн хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдөөс ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн талаар тодруулан, мэдээллийг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 21 салбарт тархаан боловсруулсан. 2015 оны судалгааны дунгээр төгсөгчид барилгын салбарт 13.4 хувь нь, боловсролын салбарт 13.1 хувь нь, төрийн удирдлага батлан хамгаалах салбарт 10.8 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 9.1 хувь байгаа нь хамгийн олонор ажиллаж байгаа салбарууд юм.

Эзэмшсэн мэргэжлийн чиглэл болон ажиллаж байгаа салбарыг 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал худалдааны салбарт 3.5 хувиар, санхүү болон даатгалын салбарт 2.0 хувиар буурсан нь энэ 2 салбарт ажиллаж байсан төгсөгчид бусад салбарт тархан ажиллаж байгааг харуулж байна. Нэг жилийн хугацаанд салбарын шилжилт хөдөлгөөн бага гарсан байна. Харин уул уурхайн салбарт 4.0 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбарт 3.2 хувиар хөдөлмөр эрхэлдэг төгсөгч нэмэгдсэн байна. Төгсөгчид олон улсын байгууллага, усан хангамж, үл хөдлөх хөрөнгийн салбаруудад маш цөөн ажиллаж байна.

Ажил хийж байгаа төгсөгчдөөс цаашид тогтвортой ажиллах талаар асуухад 82.1 хувь нь тогтвортой ажиллана гэж хариулсан ба өмнөх онд энэ үзүүлэлт 67.7 хувь байсан нь төгсөгчид тогтвортой ажиллах сонирхолтой болсныг харуулж байна.

Харин цаашид тогтвортой ажиллахгүй гэсэн шалтгааныг дэлгэрүүлэн судалвал түр ажил болохоор гэж 15.6 хувь нь, сурах хүсэлтэй гэж 15.4 хувь нь, ажлаа солих хүсэлтэй гэж 9.7 хувь нь, мэргэжлээрээ ажиллах гэж 9.5 хувь нь хариулсан байна.

Ажил хийж байгаа төгсөгчдөөс ажлын байрны мэдээллийг хаанаас авсныг тодруулахад нийт төгсөгчдийн 24.5 хувь нь эцэг эх, хамаатан садан, 22.7 хувь нь найзууд, хамт суралцагсад, 15.8 хувь нь ажил олгогч, 10.1 хувь нь интернет ажлын зар, байгууллагын вэб сайтаас гэж хариулсан байна. Нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 4.5 хувь нь буюу 1832 төгсөгч давхар ажил хийж байна. Тэдний 1205 нь ИДС төгсөгч, үлдсэн 627 нь MCYT төгсөгч байна.

Давхар ажил хийж байгаа хугацааг асуухад нийт давхар ажил хийж байгаа төгсөгчид дунджаар 18 сар хийж байна гэж хариулжээ. Эрэгтэй төгсөгчид илүү удаан буюу дунджаар 21 сар давхар ажил хийж байхад, эмэгтэй төгсөгчид дундажаар 14 сар давхар ажил хийж байна. Харин сургуулийн төрлөөр давхар ажил хийж байгаа хугацааг асуухад ИДС төгсөгч 9 сар, MCYT төгсөгч 26 сар болж байна гэж хариулсан. Одоогийн хийж байгаа үндсэн ажил нь давхар ажилтай төсөөтэй эсэхийг тодруулахад нийт давхар ажил хийж байгаа төгсөгчдийн 56.5 хувь нь ижил, 19.4 хувь нь төстэй, 24.1 хувь нь өөр гэж хариулсан. Сургуулийн төрлөөр задлан харвал ИДС төгсөгчдийн 67.8 хувь нь ижил, 11.9 хувь нь төстэй, 20.3 хувь нь өөр гэж хариулсан байхад MCYT төгсөгчид 68.4 хувь нь адилхан, 31.6 хувь нь өөр ажил эрхэлдэг гэж хариулсан байна.

Давхар ажил хийж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэрийг харвал 71.2 хувь нь цалин хөлстэй ажилтан үүнээс 40.4 хувь нь байнгын, 30.8 хувь нь түр ажилтан байна. Харин 28.8 хувь нь цалин хөлсгүй ажилтан үүнээс 3.5 хувь нь ажил олгогч, 25.3 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.

Нийт төгсөгчдийн 43.7 хувь нь буюу 26514 төгсөгч сүүлийн нэг жилд сургалтанд хамрагдаж мэдлэг үр чадвараа дээшлүүлсэн бөгөөд үүнээс 34.8 хувь нь ИДС болон MCYT-д дахин суралцсан байна.

Сургалтанд хамрагдсан дундаж хугацаа ИДС төгсөгчдийн хувьд 13.3 сар, MCYT төгсөгчдийн хувьд 10.2 сар байна. Сургалтын төлбөрт зарцуулсан зардлын дундаж хэмжээ ИДС төгсөгчдийн хувьд 1,620 мянган төгрөг байхад MCYT төгсөгчдийн хувьд 920.0 мянган төгрөг буюу 700 мянган төгрөгний зөрүү байна. Нийт суралцсан төгсөгчдийн 39.2 хувь нь өөрөө сургалтын төлбөрөө төлдөг, 30.8 хувь нь гэр булийнхнээрээ төлүүлдэг, 19.1 хувь нь байгууллага буюу ажил олгогчоор төлүүлдэг, 7.0 хувь нь буцалтгүй тусlamжид хамрагдаж үлдсэн 3.8 хувь нь үнэ төлбөргүй сургалтанд хамрагдсан гэж хариулсан.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийт 7515 төгсөгч их дээд сургууль болон мэргэжил сургалтын төвд суралцсан байна. Тэдгээр төгсөгчдөөс дахин суралцаж байгаа шалгааныг тодруулахад 44.1 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 26.8 хувь нь боловсролын түвшингээ ахиулах гэж хариулсан.

Дахин суралцаж байгаа төгсөгчдийн 41.2 хувь нь өмнөх эзэмшсэн мэргэжлээсээ өөр мэргэжлээр сурч байна. ИДС төгсөгчдөөс дахин бакалаврын зэргийн сургалтанд хамрагдаж байгаа суралцагчдын 54.1 хувь нь өмнө эзэмшсэн мэргэжлээсээ огт өөр мэргэжлээр, 34.7 хувь нь их төсөөтэй мэргэжлээр суралцаж байна. Харин магистр, докторын зэргийн сургалтанд хамрагдагсадын 64.7 хувь нь ижил мэргэжлээр суралцаж байна. Дахин суралцаж байгаа MCYT төгсөгчдийн хувьд 41.0 хувь нь 2013 онд эзэмшсэн мэргэжлээсээ огт өөр мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт суралцаж байна.

Нийт 14779 төгсөгч ажилгүй байгаагаас 6630 нь ажил хийхэд бэлэн идэвхтэй ажил хайж байхад үлдсэн 8149 төгсөгч ажил хийхэд бэлэн бус байна. Ажил идэвхтэй хайж байгаа төгсөгчдийн 2280 нь MCYT төгсөгч, 4350 нь ИДС төгсөгчид байна.

Ажилгүй байгаа төгсөгчдөөс сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн бус байсан шалгааныг нь тодруулахад 35.5 хувь нь хүүхэд асарсан, 30.5 хувь нь суралцдаг, 21.1 хувь нь гэрийн ажилтай байсан гэж хариулжээ.

Төгсөгчид хөдөлмөр зуучлалын байгууллагад бүртгүүлэх, танил талаараа дамжуулан ажил хайх нь нэмэгдсэн байна. Бодож байгаа ч тодорхой алхам хийхгүй буюу ажил хайхгүй байгаа төгсөгчид өмнөх онтой харьцуулахад 9.2 хувиар нэмэгдсэн байна.

Ажилгүй байгаа төгсөгчид дундажаар 4.2 сар ажил хайж байгаа ба ИДС төгсөгч 5.0 сар, MCYT төгсөгч 3.4 сарын дундажтай байна. Ажилд орохоор ажил олгогчид хандсан дундаж тоо ИДС төгсөгчдийн хувьд 4.1, MCYT төгсөгчдийн хувьд 3.1 удаа байна.

Эдгээр ажил хайж байгаа төгсөгчдөөс ажил хайхад гарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулсан. Нийт төгсөгчдийн 14.9 хувь болон 17.4 хувь нь ажлын байрны мэдээллийн хомсдол, ажлын туршлага дутаж байна гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Судалгаанд хамрагдсан төгсөгчдөөс 1 жилийн төлөвлөгөөг асуусан. Нийт төгсөгчдийн 27.7 хувь нь ажлаа үргэлжлүүлэн хийх, 16.3 хувь нь ажилд орох, 7.8 хувь нь дахин сурх гэж хариулсан байна. Мөн төгсөгчдөөс хүсч буй цалингийн хэмжээг тодруулахад дунджаар 1301.8 мянган төгрөг гэж хариулсан ба ИДС төгсөгч 1308.6 мянган төгрөг, MCYT төгсөгч 1295.0 мянган төгрөг гэж хариулсан нь улсын дундаж цалингаас хэт өндөр байна. Хамгийн өндөр цалинтай гэж таамагласан байгууллага нь олон улсын байгууллага байгаа ба хамгийн бага цалингаар ажиллахыг хүссэн байгууллага нь орон нутгийн өмчйт аж ахуй нэгж байгууллага байна.

БҮЛЭГ 1

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА



БҮЛЭГ 1. Судалгааны танилцуулга

1.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Судалгааны зорилго нь 2014 онд хийсэн “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-нд хамрагдсан төгсөгчдийн нэг жилийн хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг судалж дүн шинжилгээ хийхэд оршино.

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тусгасан. Үүнд:

- Төгсөгчдийн боловсролын түвшин, гэр бүлийн ахуй амьдралын талаарх өөрчлөлтийг судлах
- Төгсөгчдийн ажлын байрны хэлбэр, статус, ажил, амралтын цаг, өдөр, хөдөлмөрийн хөлс зэрэг үзүүлэлтүүдийн өөрчлөлт, давхар ажил хийж буй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн онцлогийг тодорхойлох
- Төгссөний дараах сургалттай холбоотой зүйлийг тодруулах /сургалтын төрөл, төлбөр гэх мэт/
- 2014 онд ажилгүй байсан болон одоо ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгааныг мэргэжлээр задлан судлах
- Ажил хайж байгаа төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, тэдгээрийн шалтгаан, хэлбэр болон хичээл зүтгэлийг судлах
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хэтийн төлөвлөгөө, зорилгыг судлах

1.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙДАЛ

Энэ удаагийн судалгаа нь 2014 онд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн нэг жилийн хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлтийг мөшгөж судалснаараа онцлог юм. Судалгаанд 1719 төгсөгч хамрагдсан ба 1151 нь их дээд сургууль төгсөгч, 568 нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгч болж өнгөрсөн оныхоос буурсан. Өмнөх судалгаанд хамрагдсан төгсөгчдийн хаяг, утасны дугаар өөрчлөгдөх, судалгаа өгөхөөс татгалзах, гадаад улс руу явах зэргээс шалтгаалан мөшгөх судалгаанд хамрагдсан хүмүүсийн тоо буурсан.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн тоо, хамрагдсан хувь

Хэмжих нэгж: тоо, хувь

| Сургуулийн төрөл | Мэргэжлийн чиглэл | Судалгаанд хамрагдсан төгсөгчийн тоо | Судалгаанд хамрагдсан хувь |
|------------------|---|--------------------------------------|----------------------------|
| Мэргэжил /Дээд/ | Сурган хүмүүжүүлэх ухаан | 50 | 89,3 |
| | Соёл урлаг | 52 | 92,9 |
| | Хүмүүнлэгийн ухаан | 56 | 100,0 |
| | Нийгэм, эдийн засаг | 50 | 89,3 |
| | Сэтгүүл ба мэдээлэл | 56 | 100,0 |
| | Бизнес ба мэдээлэл | 56 | 100,0 |
| | Хууль, эрх зүй | 56 | 100,0 |
| | Биологи | 56 | 100,0 |
| | Физик,Хими, Геологи газар зүй | 55 | 98,2 |
| | Математик, статистик | 56 | 100,0 |
| | Комьюнтитер | 53 | 94,6 |
| | Инженер | 56 | 100,0 |
| | Үйлдвэрлэлийн технологи | 55 | 98,2 |
| | Барилга, уран барилга | 56 | 100,0 |
| | ХАА, ОАА, ЗАА | 53 | 94,6 |
| | Мал эмнэлэг | 39 | 69,6 |
| | Анагаах ухаан | 47 | 83,9 |
| | Нийгмийн халамж, хангамж | 46 | 82,1 |
| Мэргэжил /MCYT/ | Спорт биеийн тамирын зарим төрлийн үйлчилгээ | 54 | 96,4 |
| | Тээвэр | 54 | 96,4 |
| | Хүрээлэн буй орчин | 47 | 83,9 |
| | Цагдаа, аюулгүй байдал | 48 | 85,7 |
| | Барилга, авто зам, барилгын материалын үйлдвэрлэл | 174 | 80,9 |
| | ХАА үйлдвэрлэл | 9 | 42,9 |
| | Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар | 7 | 38,9 |
| | Байгаль хамгаалагч, аялал жуулчлал | 4 | 57,1 |
| | Тээвэр | 49 | 67,1 |
| | Холбоо | 9 | 81,8 |
| | Мэдээлэл технологи | 23 | 74,2 |
| | Аж үйлдвэр | 141 | 78,3 |
| | Геологи, уул уурхайн салбар | 19 | 82,6 |
| | Захиргааны үйлчилгээний ажилтан | 118 | 67,8 |
| | Соёл урлагийн салбар | 15 | 100,0 |
| | Нийт | 1 719 | 86,0 |

Судалгаанд хамрагдсан нийт төгсөөгчдийн 70.0 хувь нь их, дээд сургууль, 33.0 хувь нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн бөгөөд 56.1 хувь нь эмэгтэйчүүд, 43.9 хувь нь эрэгтэйчүүд байв.

Нийт төгсөөгчдийн 58.1 хувь нь гэрлэгүй, 41.9 хувь нь гэрлэсэн бөгөөд өмнөх оны судалгаатай харьцуулахад 8.1 хувиар өссөн байна. Магистр зэрэгтэй их дээд сургууль төгсөөгчид 1.5 хувиар өссөн байна.

Нийт төгсөөгчдийн дунд өрхийн сарын дундаж орлого нь 501,000-750,000 төгрөг хүртэлх бүлэг хамгийн их буюу 26.6 хувь байна. Өмнөх оны түвшинтэй харьцуулахад 2 хувиар буурсан байна. Харин 750,000-1,000,000 төгрөг хүртэлх сарын дундаж орлоготой бүлэг өмнөх оны түвшинтэй харьцуулахад 2.4 хувиар өссөн байна.

БҮЛЭГ 2

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН
ТӨЛӨВ БАЙДАЛ



БҮЛЭГ 2. Хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал

Судалгаанд хамрагдсан нийт төгсөгчдийн 66.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа ба өмнөх оноос 2.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт эрэгтэй төгсөгчдийн 75.7 хувь нь, эмэгтэй төгсөгчдийн 59.8 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. 2014 оны “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-нд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 84.7 хувь нь 2015 онд ажил хийж байгаа бол 13.5 хувь нь ажилгүй, 1.9 хувь нь сурч байна. Ажилгүй байсан төгсөгчдийн 35.0 хувь нь 2015 онд ажил хийж байгаа, 61.8 хувь нь ажилгүй, үлдсэн 3.3 хувь нь сурч байна.


Зураг 2. 2014 – 2015 онд гарсан хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт

Хэмжих нэгж: хувиар



Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг бусээр харвал 2015 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт ерөнхийдөө нэмэгдэж, төвийн бүсийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өсч, хангайн бүсийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт буурсан байна.

Зураг 3. Хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид, төгссөн сургуулийн байршил буюу бүсээр, 2014, 2015 он
Хэмжих нэгж: хувиар



Их, дээд сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэл тус бүрээрх хөдөлмөр эрхлэлтийн хувийн жингиийн дундаж нь 73.0 болж өмнөх оныхос 1.0 хувиар өссөн байна.

ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг өмнөх оны судалгааны хөдөлмөр эрхлэлтийн мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад барилга, уран барилга 8.3, компьютер 10.3, нийгмийн халамж, хангамж 11.9 функтээр тус буурсан байна

Харин 80-аас дээш хувийн хөдөлмөр эрхлэлтээ хадгалж чадсан мэргэжлийн чиглэлүүд нь сурган хүмүүжүүлэх ухаан, цагдаа, аюулгүй байдлын чиглэлүүд байна. 2015 онд нийгэм, эдийн засаг мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн их буюу 87.1 хувь байна. Өмнөх онд 70-аас доош хувийн хөдөлмөр эрхлэлттэй байсан сэтгүүл ба мэдээлэл зүй 18.3 функтээр, ХАА, ОАА, ЗАА 19.8 функтээр, хүмүүнлэгийн ухаан 20.2 функтээр өссөн байна. Харин үйлдвэрлэлийн технологи мэргэжлийн чиглэлээр төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 55.0 хувиас бага байсаар л байна.

Хүснэгт 2. ИДС төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал 2014, 2015 он
/мэргэжлийн чиглэлээр/

Хэмжих нэгж: хувиар

| Мэргэжлийн салбар | Ажилтан | | Ажилгүй | |
|-------------------------------|---------|---------|---------|---------|
| | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он |
| Сурган хүмүүжүүлэх ухаан | 82,1 | 80,3 | 17,9 | 19,7 |
| Соёл урлаг | 70,0 | 63,7 | 30,0 | 36,3 |
| Хүмүүнлэгийн ухаан | 59,0 | 79,2 | 41,0 | 20,8 |
| Нийгэм, эдийн засаг | 78,9 | 87,1 | 21,1 | 12,9 |
| Сэтгүүл ба мэдээлэл | 62,5 | 80,8 | 37,5 | 19,2 |
| Бизнес ба мэдээлэл | 67,0 | 66,9 | 33,0 | 33,1 |
| Хууль, эрх зүй | 76,6 | 82,4 | 23,4 | 17,6 |
| Биологи | 63,0 | 63,6 | 37,0 | 36,4 |
| Физик,Хими, Геологи газар зүй | 76,1 | 78,3 | 23,9 | 21,7 |

| | | | | |
|--|-------------|------|-------------|------|
| Математик, статистик | 73,7 | 71,7 | 26,3 | 28,3 |
| Комьюнтипер | 72,2 | 61,9 | 27,8 | 38,1 |
| Инженер | 78,9 | 76,7 | 21,1 | 23,3 |
| Үйлдвэрлэлийн технологи | 50,0 | 54,4 | 50,0 | 45,6 |
| Барилга, уран барилга | 80,2 | 71,9 | 19,8 | 28,1 |
| ХАА, ОАА, ЗАА | 66,5 | 86,4 | 33,5 | 13,6 |
| Мал эмнэлэг | 65,9 | 62,4 | 34,1 | 37,6 |
| Анагаах ухаан | 71,4 | 63,2 | 28,6 | 36,8 |
| Нийгмийн халамж, хангамж | 66,7 | 54,8 | 33,3 | 45,2 |
| Спорт биеийн тамирын зарим төрлийн үйлчилгээ | 70,2 | 75,5 | 29,8 | 24,5 |
| Тээвэр | 74,5 | 72,0 | 25,5 | 28,0 |
| Хүрээлэн буй орчин | 60,8 | 66,2 | 39,2 | 33,8 |
| Цагдаа, аюулгүй байдал | 96,4 | 82,7 | 3,6 | 17,3 |
| ИДС төгсөгчид | 72,0 | 73,0 | 28,0 | 27,0 |

MCYT төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оныхоос 20 гаруй хувиар өссөн байна. Мэргэжлээр нь авч үзвэл ХААН үйлдвэрлэл, Ойн аж ахуй мод, соёл урлагийн салбарын мэргэжил эзэмшсэн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 40-58 хувийн өсөлттэй байна. 2015 онд хамгийн бага хөдөлмөр эрхлэлттэй буюу өмнөх оны хөдөлмөр эрхлэлтээс 43,6 хувиар буурсан үзүүлттэй байгаа нь холбооны салбарын мэргэжлүүд байна. MCYT төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг мэргэжлийн салбарын байдлаар харвал холбооны салбараас бусад нь бүгд 60.0-аас дээш хувийн хөдөлмөр эрхлэлтэй байна.

Хүснэгт 3. MCYT төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал 2014, 2015 он /мэргэжлийн чиглэлээр/

Хэмжих нэгж: хувиар


| Мэргэжлийн салбар | Ажилтан | | Ажилгүй | |
|---|-------------|-------------|-------------|-------------|
| | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он |
| Барилга, авто зам, барилгын материалын үйлдвэрлэл | 54,4 | 65,8 | 45,6 | 34,2 |
| ХАА-н үйлдвэрлэл | 31,3 | 89,2 | 68,7 | 10,8 |
| Ойн аж ахуй, мод боловсруулалтын салбар | 38,3 | 80,0 | 61,7 | 20,0 |
| Байгаль хамгаалагч, аялал жуулчлал | 51,8 | 66,7 | 48,2 | 33,3 |
| Тээвэр | 50,6 | 81,1 | 49,4 | 18,9 |
| Холбоо | 94,5 | 50,9 | 5,5 | 49,1 |
| Мэдээлэл технологи | 41,9 | 63,6 | 58,1 | 36,4 |
| Аж үйлдвэр | 44,8 | 76,7 | 55,2 | 23,3 |
| Геологи, уул уурхайн салбар | 56,1 | 71,2 | 43,9 | 28,8 |
| Захиргааны үйлчилгээний ажилтан | 60,9 | 80,2 | 39,1 | 19,8 |
| Соёл урлагийн салбар | 22,2 | 69,5 | 77,8 | 30,5 |
| MCYT төгсөгчид | 51,2 | 73,7 | 48,8 | 26,3 |

2.1 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ ТӨГСӨГЧИД

Судалгааны зорилтын нэг хэсэг нь 2014 онд ажил хийгээгүй төгсөгч 2015 онд хөдөлмөр эрхэлж байгаа эсэхийг гэдгийг тодруулах байлаа. 2014 онд ажилгүй байсан их дээд сургууль төгсөгчдийн 21.1 хувь нь, MCYT төгсөгчдийн 13.8 хувь нь 2015 онд ажил хийж байна. Өмнөх онд ажилгүй байсан их дээд сургууль төгсөгчдийн 37.5 хувь нь, MCYT төгсөгчдийн 24.3 хувь нь ажилгүй хэвээрээ байна. Харин их дээд сургууль төгсөгчдийн 1.4 хувь нь, MCYT төгсөгчдийн 1.9 хувь нь суралцаж байна

Зураг 4. 2014 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн 2015 оны хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, сургуулийн төрлөөр


Хэмжих нэгж: хувиар



Мөн 2015 онд ажилгүй байгаа төгсөгчдөөс сүүлийн нэг жилийн хугацаанд хөдөлмөр эрхэлсэн эсэхийг лавлахад 46.3 хувь нь ажил хийсэн байна. Сургуулийн төрлөөр харвал ажилгүй байгаа ИДС төгсөгчдийн 45.3 хувь, ажилгүй байгаа MCYT төгсөгчдийн 48.0 хувь нь сүүлийн нэг жилд хөдөлмөр эрхэлсэн. Ажил хийж байсан төгсөгчдөөс ажлаас гарсан шалтгааныг тодруулсан MCYT төгсөгчдийн хувьд хүхэд харах, төрөх, түр хугацааны ажил, бага цалин зэрэг нь асуудлууд ажлаас гарах гол шалтгаан болсон бол, ИДС төгсөгчдийн хувьд ажил нь түр хугацаанд зогссон болон эрүүл мэндийн шалтгаан нь зонхицж байна.

Зураг 5. 2015 онд ажилгүй байгаа боловч 2014 онд хөдөлмөр эрхэлсэн төгсөгчдийн ажлаас гарсан шалтгаан /сургуулийн төрлөөр/


Хэмжих нэгж: хувиар



Нийт төгсөгчдийн хувьд 45.9 хувь нь ар гэрийн шалтгаан болох хүүхэд асрах, төрөх, 23.8 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй гэх мэт шалтгаануудыг хамгийн ихээр нэрлэсэн байна.


Зураг 6. 2015 онд ажилгүй байгаа төгсөгчдийн ажилгүйдлийн шалтгаан, хувиар

Хэмжих нэгж: хувиар



Ажилгүй байгаа төгсөгчдөөс сүүлийн 30 хоногт ажил хайж байгаа эсэхийг тодруулахад тэдний 32.9 хувь нь ажил хайж байгаа 67.1 хувь нь ажил хайхгүй байна. Эдгээр ажилгүй байгаа ч ажил хайхгүй байгаа төгсөгчдөөс шалтгааныг асуухад 47.4 хувь нь хүүхэд, өндөр настан асрах, 30.7 хувь нь сургуульд сурх гэж хариулсан байна.

Зураг 7. 2014 онд хөдөлмөр эрхлээгүй төгсөгчдийн ажил хайхгүй байгаа шалтгаан
Хэмжих нэгж: хувиар



2.2ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГТӨГСӨГЧДИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ, ОНЦЛОГ

Судалгааны тайлангийн энэ хэсэгт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдал, онцлогийг харуулав. Одоогийн ажлын байрандаа хэдэн жил ажиллаж байгааг тодруулахад ИДС төгсөгч дунджаар 1.2 жил, MCYT төгсөгч дунджаар 1 жил ажилласан байна.

Нийт төгсөгчдийн 82.1 хувь нь байнгын ажлын байранд ажиллаж байна. Улирлын чанартай ажлын байранд ажиллагдын тоо хэмжээ нийт ажил хийж буй төгсөгчдийн 11.5 хувь байгаа бол, 5.4 хувьтай тэнцэх нь түр, 0.9 хувь нь цагийн ажил эрхэлж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь өмнөх оны судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

ИДС төгсөгчдийн олонх нь буюу 80.1 хувь нь байнгын ажил эрхэлж байгаа бол MCYT төгсөгчдийн хувьд 85.2 хувь нь байнгын ажил эрхэлж байгаа юм.

Зураг 8. Ажил хийж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэр
/сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: хувь




Нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 84.3 хувь нь нийгмийн даатгал төлдөг. Энэ дүн их дæд сургууль төгсөгчдийн хувьд 81.3 хувь, MCYT төгсөгчдийн хувьд 88.8 хувь байна. Үүнээс сайн дурын даатгал төлдөг ИДС төгсөгч 7.7 хувь, MCYT төгсөгч 5.4 хувь байна. Ажил хийж байгаа төгсөгчдөөс эрүүл мэндийн даатгал төлдөг эсэхийг асуухад нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 91.3 хувь нь төлдөг гэж хариулсан ба ИДС төгсөгчийн 90.2 хувь, MCYT төгсөгчийн 93.1 хувь нь эрүүл мэндийн даатгал төлдөг гэж тус тус хариулсан. Мөн хувь хүний орлогын албан татвар төлдөг эсэхийг лавлахад ИДС төгсөгчийн 82.6 хувь, MCYT төгсөгчийн 88.1 хувь нь төлдөг гэж хариулсан.

Нийт ажил хийдэг төгсөгчдийн 31.0 /2014 оны судалгаанд 34.0 хувь байсан, хувь нь 11-50 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй нь хамгийн олон байлаа. Мөн 23.9/өмнөх онд 27.8 хувь нь / хувь нь 10 хүртэл ажилтантай, 12.7/13.8 хувь / хувь нь 51-100 ажилтантай, 19.3 /12.5 хувь / хувь нь 251-аас дæш ажилтантай, үлдсэн 13.0 / 11.8 хувь нь/ хувь нь 101-250 ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажилласан тархалтыг харуулжээ. Ажил хийж байгаа төгсөгчид 100 ба түүнээс дæш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад ажиллах нь нэмэгдсэн нь эзэр үзүүлэлт харагдаж байна.

Монгол улсын хэмжээнд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 65.7 мянган аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 83.0 хувь нь 1-9 хүртэлх ажилтантай, 13.4 хувь нь 10-49 ажилтантай, үлдсэн 3.7 хувь нь 50-аас дæш тооны ажилтантай гэсэн статистик байна. 2014 оны төгсөгчид 50-аас дæш ажилтантай буюу томоохон аж ахуйн нэгж байгууллагад өмнөх оны судалгааны дүнтэй харьцуулахад 6.9 хувиар илүү ажиллаж байна.

Төгсөгчдийн хамгийн олноор ажиллаж буй 11-50 ажилтантай байгууллагад төрийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд 31.5 хувь, хувийн өмчийн сургууль төгсөгчдийн тухайд 29.6 хувь байгаа юм. 10 хүртэлх болон 11-50 ажилтантай байгууллагыг жижиг, дунд ААНБ гэж үзвэл хувийн өмчийн сургууль төгсөгчид нь төрийн өмчийнхнөөс илүү олноор энэ хэлбэрийн ААНБ-д ажиллаж, төрийн өмчийн сургууль төгсөгчид томоохон ААНБ-д илүү олноор ажиллаж байна. ИДС төгсөгчдийн 56.8 хувь нь 50 хүртэлх ажилтантай жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж байхад, MCYT төгсөгчдийн тухайд 52.2 хувь байна.

Зураг 9. Ажил хийж байгаа төгсөгчдийн ААНБ-ын ажилтны тооны бүлгээр, 2014, 2015 он
Хэмжих нэгж: хувиар



2015 онд ажил хийж байгаа төгсөгчдийн 95.4 хувь нь цалин хөлстэй ажилтны статусаар хөдөлмөр эрхлэгч байсан бол, тэдний 79.6 хувь нь байнгын ажилтан, 5.7 хувь нь түр ажилтан, 10.1 хувь улирлын чанартай ажилтан гэсэн үр дүнг үзүүлжээ. Харин хөдөлмөр эрхлэлтийн бусад статусын хувьд ажил олгогчийн статусаар хөдөлмөр эрхлэгч 0.6 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3.7 хувь, өрхийн бизнест оролцогч 0.3 хувь байна. MCYT төгсөгчдийн 1.9 хувь нь цалин хөлстэй ажилтны статус руу шилжилт хийсэн байна.

Хүснэгт 4. Ажил хийдэг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн статус, 2014, 2015 он
Хэмжих нэгж: хувиар

| Сургуулийн төрөл | Он | Цалин хөлстэй ажилтан | Цалин хөлсгүй ажилтан | | |
|------------------|---------|-----------------------|-----------------------|----------|---------------|
| | | | Ажил олгогч | Хувиараа | Өрхийн бизнес |
| ИДС төгсөгч | 2014 он | 96,3 | 0,4 | 3,2 | 0,1 |
| | 2015 он | 95,7 | 0,5 | 3,7 | 0,2 |
| MCYT төгсөгч | 2014 он | 93,1 | 0,9 | 5,6 | 0,4 |
| | 2015 он | 95,0 | 0,7 | 3,8 | 0,5 |

Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөөс ямар шалтгааны улмаас хувиараа хөдөлмөр эрхэлж байгааг тодруулахад цалинтай ажилтнаас илүү орлого олдог гэсэн шалтгаан 25.6 хувь буюу хамгийн өндөр, мэргэжлийн ур чадварт нийцсэн гэж 12.4 хувь, өв залгамжилсан, гэр бүлийн бизнес, аж ахуй байсан гэж 10.1 хувь нь хариулсан байна.

Их дээд сургууль төгссөн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчид цалинтай ажилтнаас илүү орлого олдог /25.5 хувь/, мэргэжил ур чадварт нийцсэн /15.2 хувь/, орлого амжиргаанд хүрэлцэхгүй байсан /12.5 хувь/, цагт баригдаж ажиллах сонирхолгүй /10.2 хувь/ гэсэн шалтгаануудыг их дурьджээ. Харин MCYT төгсөгчид цалинтай ажилтнаас илүү орлого олдог /25.6 хувь/, өв залгамжилсан, гэр бүлийн бизнес, аж ахуй байсан /11.9 хувь/, өөр ажил байгаагүй /11.3 хувь/ гэсэн шалтгааныг илүү тулхүү нэрлэжээ.

Зураг 10. Хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа шалтгаан /сургуулийн төрлөөр/


Хэмжих нэгж: хувиар



Цалин хөлстэй ажилтны хувьд хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид 10.0 хувиар өссөн байна. 2015 онд хувийн өмчийн ИДС төгсөгчдийн хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах хувь буурсан хэдий ч MCYT төгсөгчдийн хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах нь 33.4 хувиар өссөн байна. Өмнөх онтой харьцуулахад MCYT төгсөгчдийн хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах нь 31.7 хувиар өссөн байна. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг болох хөдөлмөрийн гэрээтэй MCYT төгсөгчдийн тоо өсөж байгаа эерэг дүн харагдаж байна.

Зураг 11. Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа төгсөгчид сургуулийн төрөл, өмчийн хэлбэр, 2014, 2015 оны байдлаар


Хэмжих нэгж: хувиар



Хөдөлмөрийн гэрээг хугацаатай болон хугацаагүй байгуулдаг бөгөөд их, дээд сургууль төгсөгчдийн 60.5 хувь нь, MCYT төгсөгчдийн 55.3 хувь нь хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Төгсөгчдийн ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын төрлийг судлан үзэхэд хамгийн олноороо ажилладаг нь дотоодын хөрөнгө оруулалттай компани, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллага төдийгүй хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

Зураг 12. Ажил хийдэг төгсөгчдийн ажил олгогч байгууллагын хэлбэр 2014, 2015 он

Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын өдрийн хувьд өөрчлөлт бага байна. Харин 7 хоногийн дундаж ажлын цаг 1.5 цагаар багассан байна. MCYT төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын цаг 5.8 цагаар багассан байна. 7 хоногийн нэмэлт ажлын цагийн хувьд 1.1 цагаар өсчээ. Үүнд хувийн өмчийн сургууль төгсөгчдийн нэмэлт ажлын цаг 2.8 цагаар нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Ажил хийдэг төгсөгчдийн 7 хоногийн дундаж ажлын өдөр, цагаар 2014,2015 он /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/

Хэмжих нэгж: тоо

| Ангилал | 7 хоногийн дундаж ажлын өдөр | | 7 хоногийн дундаж ажлын цаг | | 7 хоногийн нэмэлт ажлын цаг | | |
|--------------------------|------------------------------|------------|-----------------------------|-------------|-----------------------------|-------------|------|
| | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он | |
| Сургуулийн төрөл | ИДС төгсөгч | 5,3 | 5,4 | 45,9 | 46,7 | 12,0 | 12,3 |
| | MCYT төгсөгч | 5,6 | 5,2 | 50,4 | 44,6 | 9,8 | 10,2 |
| Сургуулийн өмчийн хэлбэр | Төрийн | 5,4 | 5,3 | 47,3 | 45,6 | 12,1 | 13,2 |
| | Хувийн | 5,4 | 5,4 | 47,4 | 48,0 | 9,5 | 12,3 |
| Дундаж/ИДС+MCYT/ | 5,5 | 5,3 | 47,7 | 46,2 | 10,9 | 12,0 | |

Сарын дундаж ажлын өдөр, амралтын өдөр нэг жилийн хугацаанд онц өөрчлөгдөөгүй байна. MCYT төгсөгчдийн сарын дундаж ажлын өдөр 1 өдрөөр багассан байна.

Төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ 1 жилийн өмнөх үеэс 98.2 мянган төгрөгөөр өссөн байна. MCYT төгсөгчдийн цалин 159.8 мянган төгрөгөөр өссөн нь хамгийн их, ИДС төгсөгчдийн цалин 35.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

2015 онд төгсөгчдийн сарын дундаж цалин, орлогын хэмжээ нь 708.2 мянган төгрөг байгаа ба ХЭҮСМҮТ-ийн “Цалин хөлслний бүтцийн судалгаа-2015”-аар ААНБ-ын ажиллагчдын улсын дундаж 705.2 мянган төгрөг гэсэн байна. Үүнээс харахад

төгсөгчдийн дундаж цалин, цалин хөлсний бүтцийн судалгааны улсын дундажтай харьцуулахад зөрүү бага байна.

Терийн өмчийн болон хувийн өмчийн сургууль төгсөгчдийн цалин, орлогын дунджаад 78,5 мянган төгрөгийн ялгаа байгаа бөгөөд хувийн сургууль төсгөч илүү цалин авч байна. Түүнчлэн MCYT төгсөгчийн цалин 729,7 мянга байгаа нь ИДС төгсөгчөөс 7,0 хувиар илүү байна.

Хүснэгт 6. Ажил хийдэг төгсөгчдийн сарын дундаж ажил, амралтын өдөр, цалингийн хэмжээ 2014, 2015 он /сургуулийн төрөл, өмчийн хэлбэрээр/ Хэмжих нэгж: хувь, тоо

| Ангилал | | Сарын дундаж амралтын өдөр | | Сарын дундаж ажлын өдөр | | Сарын дундаж цалин орлого /мян төгрөг/ | |
|--------------------------|--------|----------------------------|---------|-------------------------|---------|--|---------|
| | | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он | 2014 он | 2015 он |
| Сургуулийн төрөл | ИДС | 7,7 | 7,6 | 23,0 | 23,7 | 642464 | 678254 |
| | MCYT | 7,4 | 7,8 | 24,0 | 23,0 | 569872 | 729757 |
| Сургуулийн өмчийн хэлбэр | Терийн | 7,5 | 7,7 | 23,4 | 23,4 | 624991 | 673174 |
| | Хувийн | 7,7 | 7,6 | 23,2 | 23,7 | 602570 | 751709 |
| Дундаж/ИДС+MCYT/ | | 8 | 8 | 23 | 23 | 609974 | 708223 |

Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийн түвшин өмнөх оны судалгаатай ижил түвшинд байна. Байгууллагын нэр хүндийн сэтгэл ханамж ердийнөөс хангалуун болсон байна. Харин ажил, амралтын цагийн талаар сэтгэл ханамжийн түвшин өөрчлөгдөөгүй байна. Ер нь ажлын байрны сэтгэл ханамжийн түвшин ердийн буюу хангалуун гэсэн түвшинд хүрэхгүй байна. 2015 онд төгсөгчдийн ажлын байрны хамгийн сэтгэл ханамжтай байдаг үзүүлэлт нь байгууллагын нэр хүнд байна.

Хүснэгт 7. Ажлын байрны сэтгэл ханамж 2014, 2015 он /сургуулийн төрөл/ Хэмжих нэгж: 1-5 хүртэлх үнэлгээний онооны дундаж

| Ангилал | | Цалин | Хөдөлмерийн нөхцөл, аюулгүй ажиллагаа | Хариуцаж буй ажил | Ажлын орчин | Ажил, амралтын өдөр | Өсөн хөгжих боломж | Ажлын байрны хангамж | Хүний нөөцийн менежмент | Ажил мэргэжлийн үнэлэмж | Байгууллагын нэр хүнд |
|--------------|---------|-------|---------------------------------------|-------------------|-------------|---------------------|--------------------|----------------------|-------------------------|-------------------------|-----------------------|
| ИДС төгсөгч | 2014 он | 3,6 | 3,9 | 4,0 | 3,9 | 3,7 | 3,9 | 3,8 | 3,7 | 3,9 | 4,1 |
| | 2015 он | 3,8 | 3,7 | 4,0 | 3,8 | 3,6 | 3,6 | 3,6 | 3,4 | 3,6 | 4,1 |
| MCYT төгсөгч | 2014 он | 3,6 | 3,7 | 3,7 | 3,8 | 3,5 | 3,5 | 3,6 | 3,5 | 3,7 | 3,7 |
| | 2015 он | 3,8 | 3,7 | 4,0 | 3,7 | 3,6 | 3,6 | 3,6 | 3,5 | 3,7 | 4,1 |
| Дундаж | 2014 он | 3,6 | 3,8 | 3,9 | 3,8 | 3,6 | 3,7 | 3,7 | 3,6 | 3,8 | 3,9 |
| | 2015 он | 3,8 | 3,7 | 4,0 | 3,7 | 3,6 | 3,6 | 3,6 | 3,5 | 3,7 | 4,1 |

Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг, боловсролын түвшингийн тохиромжтой байдал өмнөх оноос 7.3 хувиар буурч 68.6 хувь болсон байна. Энэ үзүүлэлт нь боловсролоос хамаарсан ажил үүргийн үл нийцэл байгааг харуулж байна.

ИДС, MCYT-ийн төрлөөр ажлын байрны ажил үүргийн шаардлага, боловсролын түвшинг тохиромжтой эсэхийг харвал 69.2, 67.6 хувь байна. Эндээс ИДС төгсөгчдөд MCYT төгсөгчдөөс илүү боловсрол, ажил үүргийн үл нийцэл харагдаж байна.

Хүснэгт 8. Боловсролын түвшин, ажил үүргийн нийцтэй байдал 2014, 2015 он /сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Хэт доогуур | Доогуур | Тохиромжтой | Өндөр | Хэт өндөр |
|--------------|----------------|-------------|-------------|-------------|-------------|------------|
| Бүгд | 2014 он | 2,7 | 12,6 | 75,9 | 7,0 | 1,8 |
| | 2015 он | 2,2 | 12,1 | 68,6 | 14,2 | 2,8 |
| ИДС төгсөгч | 2014 он | 3,2 | 9,4 | 78,5 | 7,0 | 1,9 |
| | 2015 он | 2,2 | 10,6 | 69,2 | 14,4 | 3,6 |
| MCYT төгсөгч | 2014 он | 1,6 | 19,6 | 70,2 | 7,1 | 1,5 |
| | 2015 он | 2,3 | 14,4 | 67,6 | 14,0 | 1,7 |

Төгсөгчид төгссөнөөс хойш 2.5-3 жилийн дараа ур чадварын зөрүү байсаар байгаа нь харагдаж байна. 2015 онд ажил үүргийн шаардлага, ур чадвараас өндөр гэсэн хариулт өмнөх оноос 8.1 хувиар өссөн байна. Ажил үүргийн шаардлага, ур чадварын тохиромжтой байдлыг сургуулийн төрлөөр харвал MCYT төгсөгчид 71.8 хувь, ИДС төгсөгчид 68.9 хувь байна.

Хүснэгт 9. Ажил үүргийн шаардлага, ур чадварын нийцтэй байдал 2014, 2015 он /сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Хэт доогуур | Доогуур | Тохиромжтой | Өндөр | Хэт өндөр |
|--------------|----------------|-------------|-------------|-------------|-------------|------------|
| Бүгд | 2014 он | 2,4 | 11,6 | 75,9 | 9,6 | 0,5 |
| | 2015 он | 2,1 | 9,6 | 70,0 | 16,4 | 1,8 |
| ИДС төгсөгч | 2014 он | 2,6 | 9,1 | 78,7 | 9,5 | 0,2 |
| | 2015 он | 2,3 | 9,4 | 68,9 | 17,8 | 1,8 |
| MCYT төгсөгч | 2014 он | 2,1 | 16,9 | 70,2 | 9,7 | 1,1 |
| | 2015 он | 1,9 | 10,1 | 71,8 | 14,4 | 1,9 |

Өмнөх оны судалгаанд хамгийн олноор нэрлэсэн ур чадварын хомсдол болох гадаад хэлний мэдлэг, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал, багаар ажиллах чадварууд энэ онд ч байсаар л байна. Харин бусадтайгаа харьцуулахад шинжлэх ухаан, технологийн ур чадварын хомсдол 4.5 хувиар буурсан бол гадаад хэлний мэдлэгийн ур чадварын хомсдол 8.7 хувиар өссөн байна. MCYT төгсөгчдийн хувьд хамгийн ихээр дутагдаж байгаа ур чадвар нь гадаад хэлээр харилцах,

мэдээллийн технологийг ашиглаж эзэмших байсан бол, ИДС төгсөгчдийн хувьд гадаад хэлний мэдлэг, харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал, багаар ажиллах чадварууд байна. Цаашид дараа дараагийн төгсөгчдөд эдгээр дутагдалтай байгаа ур чадвар, мэдээгийг хичээлийн хөтөлбөрт нь илүү тусгаж өгэх, хэвшил болгон хэрэглэж сурахад нь анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Хөдөлмөрийн зах зээлд шаардагдаж байгаа эдгээр ур чадварыг эзэмшүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Өмнөх онтой харьцуулахад MCYT төгсөгчдийн багаар ажиллах чадвар 9.2 хувиар, шинжлэх ухаан технологийн мэдлэг 6.4 хувиар буурсан байгаа нь ажлын байран дахь ур чадварын хомсдол нь багасч байна.

Хүснэгт 10. Ажлын байран дахь ур чадварын хомсдол 2014, 2015 он /сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Төрөлх хэлээр зөв бичих, ярих ур чадвар | Гадаад хэлээр харилцах | Математик сэтгэлгээ, тооцоолон бодх чадвар | Шинжлэх ухаан, технологийн мэдлэг | Тасралтгүй суралцах ур чадвар | Харилцааны ур чадвар, соёлч боловсон байдал | Асуудлыг шийдвэрлэх, зөв зохицостой хандлагыг тодорхойлох | Мэдээллийн технологийг ашиглах, эзэмших | Багаар ажиллах чадвар | Олон улсын мэдлэг | Бусад |
|--------------|------|---|------------------------|--|-----------------------------------|-------------------------------|---|---|---|-----------------------|-------------------|-------|
| ИДС төгсөгч | 2014 | 4,0 | 20,9 | 5,1 | 11,2 | 3,4 | 9,3 | 7,6 | 11,9 | 8,2 | 14,4 | 4,0 |
| | 2015 | 2,6 | 26,6 | 8,4 | 7,5 | 5,6 | 11,6 | 5,4 | 8,8 | 11,5 | 7,3 | 4,7 |
| MCYT төгсөгч | 2014 | 2,8 | 12,0 | 8,5 | 13,4 | 5,0 | 15,3 | 6,3 | 11,5 | 18,9 | 3,4 | 3,0 |
| | 2015 | 3,4 | 28,0 | 6,6 | 7,0 | 6,2 | 9,8 | 5,3 | 11,3 | 9,7 | 9,8 | 2,9 |
| Бүгд | 2014 | 3,6 | 18,5 | 6,0 | 11,8 | 3,8 | 11,0 | 7,2 | 11,8 | 11,1 | 11,3 | 3,7 |
| | 2015 | 2,9 | 27,1 | 7,7 | 7,3 | 5,8 | 10,9 | 5,4 | 9,8 | 10,8 | 8,3 | 4,0 |

Сургууль төгсөөд 2.5-3 жилийн дараа 42.2 хувь нь ажлын байранд дасан зохицоход ямар нэг хүндрэл бэрхшээл тулгардаггүй гэж хариулсан байна. Энэ нь нэг жилийн өмнөх үзүүлэлтээс 19.8 хувиар буурсан бөгөөд төгсөөд удах тусам ажлын байранд дасан зохицоход тулгардаг хүндрэл бэрхшээл нь багасч байна. Төгсөгчдийн 12.5 хувь нь ажлын хэв маягт дасан зохицох байдал мөн адил 12.5 хувь нь ажлын туршлага дутах гэж хариулсан ба хамгийн ихээр тулгардаг бэрхшээлүүд байна.

Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн хувьдажлын хэв маягт дасах байдал, MCYT төгсөгчдийн хувьд ажлын туршлага дутах байдал илүү их бэрхшээл болдог байна.

Хүснэгт 11. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл 2014, 2015 он
/сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Ажлын хэв маягт дасах байдал | Хамт ажиллагсад, даргатай харилцаа | Ажилд тохиорх байдал болон сонирхлын үл нийцэл | Хүснэгт 11. Ажлын байранд дасан зохицоход тулгардаг бэрхшээл 2014, 2015 он /сургуулийн төрөл/ Хэмжих нэгж: хувиар | Ажил, гэр хоорондын зайн байдлын цаг | Хүндэрэл бэрхшээл байгаагүй | Ажлын туршилага дутах | Бусад |
|--------------|------|------------------------------|------------------------------------|--|---|--------------------------------------|-----------------------------|-----------------------|-------|
| ИДС төгсөгч | 2014 | 13,4 | 6,5 | 3,5 | 9,6 | 4,6 | 57,5 | 0,0 | 4,9 |
| | 2015 | 12,3 | 8,5 | 1,7 | 3,5 | 7,5 | 43,4 | 11,1 | 12,1 |
| МСҮТ төгсөгч | 2014 | 9,7 | 3,9 | 2,2 | 6,7 | 3,8 | 71,8 | 0,0 | 1,9 |
| | 2015 | 12,9 | 8,7 | 2,6 | 3,2 | 6,3 | 40,5 | 14,5 | 11,3 |
| Бүгд | 2014 | 12,2 | 5,7 | 3,1 | 8,7 | 4,4 | 62,0 | 0,0 | 4,0 |
| | 2015 | 12,5 | 8,5 | 2,1 | 3,3 | 7,0 | 42,2 | 12,5 | 11,8 |

Ажилд ороход хамгийн ихээр нөлөөлдөг хүчин зүйл нь эзэмшсэн мэргэжил байна. Түүний дараа хувийн зан чанар, төгссөн сургууль, сурлагын дүн, оноо гэсэн хүчин зүйлүүд орсон байна. Харин өмнөх онд ярилцлагын ур чадвар их нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг байсан бол энэ жил хувийн зан чанар ихээхэн нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг болсон байна.

Хүснэгт 12. Ажилд ороход нөлөөлдөг хүчин зүйлс 2014, 2015 он/сургуулийн төрөл/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Сурлагын дүн, оноо | Мэргэжил | Мэргэжил, ур чадварын үнэмлэх | Төгсөн сургууль | Ярилцлагын ур чадвар | Хөдөлмөр бэлтгэх ур чадвар | Хувийн зан чанар | Гадаад дүр төрх, бие баялдарын хөгжил | Аль нь ч нөлөөлөөгүй | Гадаад хэлний мэдлэг | Бусад |
|--------------|------|--------------------|----------|-------------------------------|-----------------|----------------------|----------------------------|------------------|---------------------------------------|----------------------|----------------------|-------|
| ИДС төгсөгч | 2014 | 11,6 | 18,1 | 7,6 | 12,9 | 14,1 | 9,0 | 9,3 | 5,8 | 1,9 | 4,0 | 5,7 |
| | 2015 | 10,7 | 20,5 | 8,4 | 11,1 | 8,6 | 3,3 | 13,8 | 2,6 | 7,0 | 3,1 | 10,8 |
| МСҮТ төгсөгч | 2014 | 5,8 | 20,9 | 14,6 | 10,6 | 8,9 | 5,9 | 9,2 | 12,0 | 5,9 | 0,8 | 5,4 |
| | 2015 | 12,0 | 21,4 | 6,3 | 12,6 | 10,5 | 3,6 | 16,6 | 1,1 | 5,3 | 3,5 | 6,9 |
| Бүгд | 2014 | 10,2 | 18,8 | 9,3 | 12,4 | 12,8 | 8,2 | 9,3 | 7,3 | 2,9 | 3,2 | 5,6 |
| | 2015 | 11,2 | 20,9 | 7,6 | 11,7 | 9,4 | 3,4 | 15,0 | 2,0 | 6,3 | 3,3 | 9,2 |

Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдлын талаар 45.6 хувь нь тохирдог, маш сайн тохирдог гэж 20.1 хувь нь хариулсанаас үзэхэд нийт ажилтай төгсөгчдийн 65.8 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ ажилладаг гэж үзэж болохоор байна. ИДС төгсөгчдийн хувьд 70-аас дээш хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлүүд нь бизнес ба мэдээлэл, ХАА, ОАА, ЗАА, нийгмийн халамж, хангамж, нийгэм эдийн засаг, сурган хүмүүжүүлэх ухаан, 60-70 хүртэл хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлүүд нь барилга, мэдээлэл-сэтгүүл зүй, биологи, тээвэр, хүрээлэн буй орчин зэрэг мэргэжлүүд байна. MCYT төгсөгчдийн хувьд 70-аас дээш хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлүүд нь ХАА-н үйлдвэрлэл, холбоо, геологи уул уурхайн салбарын мэргэжлүүд байна.

Харин мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлт ихтэй мэргэжлүүд нь MCYT төгсөгчдийн хувьд байгаль хамгаалал аялал жуулчлал, мэдээллийн технологийн салбарын мэргэжлүүд бөгөөд эдгээр чиглэлээр төгсөгчдийн 50 хувь нь огт өөр мэргэжлээр хөдөлмөр эрхэлж байгаа нь харагдаж байна. Харин ИДС төгсөгчдийн хувьд 35-40 хувь нь мэргэжлээрээ ажиллахгүй байгаа мэргэжлийн салбарууд нь үйлдвэрлэлийн технологи, математик, статистик хууль, эрх зүй, спорт, биеийн тамирын зарим төрлийн үйлчилгээ зэрэг байна. Эзэмшсэн мэргэжлийн чиглэл болон ажил үүргийн нийцлийн дэлгэрэнгүй хүснэгтийг хавсралт 2-оос үзнэ үү.

Хүснэгт 13. Ажил үүрэг, эзэмшсэн мэргэжлийн нийцтэй байдал 2014, 2015 он
/сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Огт тохирдог-гүй | Тохирдог-гүй | Дунд зэрэг | Тохирдог | Маш сайн тохирдог |
|--------------|------|------------------|--------------|------------|----------|-------------------|
| ИДС төгсөгч | 2014 | 7,0 | 11,7 | 18,9 | 41,2 | 21,2 |
| | 2015 | 14,8 | 5,3 | 12,6 | 45,1 | 22,2 |
| MCYT төгсөгч | 2014 | 17,1 | 12,8 | 15,2 | 30,3 | 24,6 |
| | 2015 | 13,2 | 12,5 | 10,8 | 46,5 | 17,0 |
| Бүгд | 2014 | 10,7 | 12,1 | 17,5 | 37,2 | 22,4 |
| | 2015 | 14,2 | 8,2 | 11,9 | 45,6 | 20,1 |

Төгсөгчдөөс ажиллаж буй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн талаар тодруулан, мэдээллийг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 21 салбарт тархаан боловсруулсан. 2015 оны судалгааны дүнгээр төгсөгчид барилгын салбарт 13.4 хувь нь, боловсролын салбарт 13.1 хувь нь, төрийн удирдлага батлан хамгаалах салбарт 10.8 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарт 9.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засварын салбарт 8.1 хувь байгаа нь хамгийн олноор ажиллаж байгаа салбарууд юм.

Эзэмшсэн мэргэжлийн чиглэл болон ажиллаж байгаа салбарыг 2014 оны судалгааны үр дүнтэй харьцуулбал худалдааны салбарт 3.5 хувиар буурсан, санхүү болон даатгалын салбарт 2.0 хувиар буурсан нь энэ 2 салбарт ажиллаж байсан төгсөгчид бусад салбарт шилжин ажиллаж байгааг харуулж байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд ажилладаг салбарын хувьд шилжих хөдөлгөөн бага байна. Харин


уул уурхайн салбарт 4.0 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбарт 3.2 хувиар хөдөлмөр эрхэлдэг төгсөгч нэмэгдсэн байна.

Төгсөгчид олон улсын байгууллага, усан хангамж, үл хөдлөх хөрөнгийн салбаруудад маш цөөнөөр ажиллаж байна.

Төгсөгчдийн мэргэжлийн чиглэл, ажилладаг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын тархалтыг харьцуулсан дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 2-оос харах боломжтой.

Зураг 13. Ажил хийдэг төгсөгчдийн ажил мэргэжлийн ангилаал /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдийн хамгийн олноор ажилладаг ажил мэргэжлүүд нь "мэргэжилтэн" гэсэн ажил мэргэжлийн үндсэн бүлэгт харьялагдаж байгаа юм. Мөн "худалдаа, үйлчилгээний ажилтан" болон "инженер, техникийн ажилтан" гэсэн ажил мэргэжлийн үндсэн бүлгүүдэд хамаарах ажил мэргэжлүүдээр илүү олноор тархан ажилладаг нь тогтоогдсон.

Ажил хийж байгаа төгсөгчдөөс цаашид тогтвортой ажиллах эсэх талаар асуухад 82.1 хувь нь тогтвортой ажиллана гэж хариулсан ба өмнөх онд 67.7 хувь байсан нь төгсөгчид илүү тогтвортой ажиллах сонирхолтой болсныг харуулж байна. Энэ үзүүлэлт ИДС төгсөгчдийн хувьд 81.8 хувь /2014 онд 76.9 хувь байсан/, MCYT 82.6 хувь /2014 онд 63.8 хувь байсан/байна.

Цаашид тогтвортой ажиллах үндсэн шалтгааныг сургуулийн төрлөөр тодруулахад ажилдаа сэтгэл ханамжтай /31.3 хувь/ гэсэн хариулт өндөр хувьтай байсан ба дараа нь өсөж хөгжих боломжтой /18.2 хувь/, тогтмол орлоготой учраас / 10. 3 хувь / гэсэн хариултууд байна.


Зураг 14. Ажил хийдэг төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллах шалтгаан/сургуулийн төрөл/
Хэмжих нэгж: хувиар



Харин цаашид тогтвортой ажиллахгүй гэсэн шалтгааныг дэлгэрүүлэн судалвал түр ажил болохоор гэж 15.6 хувь нь, сурх хүсэлтэй гэж 15.4 хувь нь, ажлаа солих хүсэлтэй гэж 9.7 хувь нь, мэргэжлээрээ ажиллах гэж 9.5 хувь нь хариулсан байна.

Их дээд сургууль төгсөгчдийн хувьд түр ажиллаж байгаа гэж 17.8 хувь нь, сурх хүсэлтэй гэж 15.9 хувь нь, мэргэжлээрээ ажиллах хүсэлтэй 11.8 хувь нь, ажлаа солих хүсэлтэй гэж 11.8 хувь нь хариулсан бол MCYT төгсөгчдийн хувьд 12 хувь нь түр ажиллаж байгаа учраас, 14.6 хувь нь сурх, 10.8 хувь нь илүү хөгжих боломжтой ажил хийх гэсэн шалтгаанаар цаашид ажиллахгүй гэсэн байна.

Зураг 15. Ажил хийдэг төгсөгчдийн цаашид тогтвортой ажиллахгүй шалтгаан
/сургуулийн төрөл/
хэмжих нэгж: хувиар




Ажил хийж байгаа төгсөгчдөөс ажлын байрны мэдээллийг хаанаас авсныг тодруулахад нийт төгсөгчдийн 24.5 хувь нь эцэг эх, хамаатан садан, 22.7 хувь нь найзууд, хамт суралцагсад, 15.8 хувь нь ажил олгогч, 10.1 хувь нь интернет

ажлын зар, байгууллагын вэб сайтаас гэж хариулсан байна. Сургуулийн төрлөөр харвал MCYT төгсөгчдийн 26.7 хувь нь ажлын байрны мэдээллийг эцэг эх, хамаатан саданаас авдаг буюу хамгийн өндөр байна. ИДС төгсөгчид мөн адил 23.1 хувь нь буюу хамгийн өндөр хувь эцэг эх, хамаатан саданаасаа ажлын байрны мэдээллээ авдаг нь сонирхолтой үр дүн байна. Үүнээс гадна ажлын байрыг өөрөө бий болгосон гэсэн төгсөгчид MCYT-ийн хувьд 4.3 хувь, ИДС-ийн хувьд 5.6 хувь байна.

Зураг 16. Ажлын байрны мэдээллийн эх сурвалж /сургуулийн төрлөөр/

хэмжих нэгж: хувиар



2.3 ДАВХАР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Энэ хэсэгт одоо хийж байгаа ажлаасаа гадна 1 ба түүнээс дээш ажил давхар хийж байгаа төгсөгчдийн талаар судласан юм. Хийж буй давхар ажлын тоо, ажлын цаг, давхар ажил, хийж буй шалтгаан, ажлын байрны хэлбэр зэрэг үзүүлэлтүүдийг тусгасан. Нийт ажил хийж байгаа төгсөгчдийн 4.5 хувь нь буюу 1832 төгсөгч давхар ажил хийж байна. Тэдний 1205 нь ИДС тögсөгч, үлдсэн 627 нь MCYT тögсөгч байна.

Давхар ажил хийж байгаа хугацааг асуухад нийт давхар ажил хийж байгаа төгсөгчид дунджаар 18 сар хийж байна гэж хариулсан ба эрэгтэй төгсөгчид илүү удаан давхар ажил хийж байгаа буюу дунджаар 21 сар, эмэгтэй төгсөгчид 14 сар давхар ажил хийж байна. Харин сургуулийн төрлөөр давхар ажил хийж байгаа хугацааг асуухад ИДС тögсөгч 9 сар, MCYT тögсөгч 26 сар болж байна гэж хариулсан.

Одоогийн хийж байгаа үндсэн ажил давхар ажилтай төсөөтэй эсэхийг тодруулахад нийт давхар ажил хийж байгаа төгсөгчдийн 56.5 хувь нь ижил, 19.4 хувь нь төстэй, 24.1 хувь нь өөр гэж хариулсан. Сургуулийн төрлөөр задлан харвал ИДС төгсөгчийн 67.8 хувь нь ижил, 11.9 хувь нь төстэй, 20.3 хувь нь өөр гэж хариулсан байхад MCYT төгсөгчид 68.4 хувь нь өөр ажил эрхэлдэг байна.

Давхар ажил хийж байгаа төгсөгчдийн ажлын байрны хэлбэрийг харвал 71.2 хувь нь цалин хөлстэй ажилтан, үүнээс 40.4 хувь нь байнгын, 30.8 хувь нь түр ажилтан байна. Харин 28.8 хувь нь цалин хөлсгүй ажилтан үүнээс 3.5 хувь нь ажил олгогч, 25.3 хувь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Сургуулийн төрлөөр хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 14. Давхар ажил эрхэлдэг төгсөгчдийн ажлын байрны хэлбэр /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж:хувиар

| Ангилал | | Цалин хөлстэй ажилтан | | Цалин хөлсгүй ажилтан | | Бүгд |
|------------------|--------------|-----------------------|------|-----------------------|----------|-------|
| | | Байнгын | Түр | Ажил олгогч | Хувиараа | |
| Сургуулийн төрөл | ИДС төгсөгч | 43,9 | 26,5 | 0,2 | 29,4 | 100,0 |
| | MCYT төгсөгч | 33,6 | 39,2 | 9,9 | 17,4 | 100,0 |

Давхар ажил хийж байгаа 7 хоногийн дундаж цаг 11.1, сургуулийн төрлөөр ИДС төгсөгчийн хувьд 15.1 цаг, MCYT төгсөгч 7.1 цаг ажиллаж байна. Харин давхар ажил хийгээд авч буй сарын цалин орлого дунджаар 359,8 мянган төгрөг байна.

Хүснэгт 15. Давхар ажил эрхэлдэг төгсөгчдийн ажлын цаг, цалин орлого /сургуулийн төрлөөр/


Хэмжих нэгж:хувиар

| Ангилал | | 7 хоногын ажлын цаг | | Сарын цалин, орлого | | Сарын дундаж цалин, орлого |
|------------------|------|---------------------|---------|---------------------|---------|----------------------------|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй | |
| Сургуулийн төрөл | ИДС | 15 | 15 | 412 510 | 460 650 | 436 580 |
| | MCYT | 8 | 6 | 376 428 | 189 702 | 283 065 |
| Дундаж | | 12 | 10 | 394469 | 325176 | 359 822 |

Нийт давхар ажил хийж буй төгсөгчдөөс давхар ажил хийх нь ирээдүйн ажил мэргэжилд нөлөөлнө гэж 71.0 хувь нь үзэж байгаа бол 23.6 хувь нь нөлөөлөхгүй, үлдсэн 5.4 хувь нь мэдэхгүй гэсэн байна.

Давхар ажил хийж байгаа шалтгааныг тодруулахад цалин орлогоо нэмэгдүүлэх гэж /37.6 хувь/ давхар ажил хийдэг гэсэн хариулт хамгийн их байна. Дараа нь ажлын туршлага хуримтлуулах /29.5 хувь/, өөрийн хүсэл сонирхлоор /17.1 хувь/ давхар ажил хийж байгаа гэсэн хариултууд байна. Сургуулийн төрлөөр авч үзвэл ИДС төгсөгчдийн 27.9 хувь нь цалин орлогоо нэмэгдүүлэх, MCYT төгсөгчдийн 12 хувь нь ажлын туршлага хуримтлуулах гэсэн хариултууд хамгийн их хувь эзэлж байна.

Зураг 17. Давхар ажил хийж буй шалтгаан /сургуулийн төрлөөр/ хэмжих нэгж: хувиар



Хийж буй давхар ажлын байрны мэдээллийг хаанаас авсан талаар лавлахад 38.4 хувь нь найз нөхөд, 23.0 хувь нь ажил олгогч, 11.4 хувь нь эцэг эх, хамаатан саданаас авсан гэсэн байна. Сургуулийн төрлөөр харахад ажлын байрны мэдээллээ MCYT төгсөгчдийн 39.4 хувь нь, ИДС төгсөгчдийн 38.0 хувь нь тус тус эцэг эх, хамаатан садангаас авсан гэжээ.

БҮЛЭГ 3

СҮҮЛИЙН НЭГ ЖИЛД СУРГАЛТАНД
ХАМРАГДСАН БАЙДАЛ



БҮЛЭГ 3. Сүүлийн нэг жилд сургалтанд хамрагдсан байдал

Нийт төгсөгчдийн 43.7 хувь нь буюу 26514 төгсөгч сүүлийн нэг жилд сургалтанд хамрагдсан бөгөөд үүнээс 34.8 хувь нь ИДС болон MCYT-д дахин суралцсан байна.

Сургалтанд хамрагдсан дундаж хугацаа ИДС төгсөгчдийн хувьд 13.3 сар, MCYT төгсөгчдийн хувьд 10.2 сар байна. Сургалтын төлбөрт зарцуулсан дундаж хэмжээ ИДС төгсөгчдийн хувьд 1,620 мянган төгрөг байхад MCYT төгсөгчдийн хувьд 920.0 мянган төгрөг буюу 700 мянган төгрөгний зөрүү байна.

Хүснэгт 16. Суралцсан сургалтын төрөл, сургуулийн төрлөөр

Хэмжих нэгж: хувиар


| Ангилал | | Суралцаж байгаа /суралцсан/ сургалтын төрөл | | | | | | | | |
|------------------|---------------|---|------------|---------------------|------------------------|----------------------|-------------------------|----------|-----------------|------|
| | TOEIC / TOEFL | Аж ахуй эрхлэх сургалт | Гадаад хэл | Үр чадварын сургалт | Мэргэжлийн түр сургалт | Мэргэжлийн анхан шат | Тусгай мэргэжлийн дунд. | Бакалавр | Магистр, доктор | |
| Сургуулийн төрөл | ИДС | 1,6 | 1,5 | 9,6 | 23,3 | 25,2 | 0,2 | 1,5 | 23,6 | 13,5 |
| | MCYT | 0,3 | 1,8 | 12,5 | 30,4 | 26,0 | 0,3 | 0,4 | 15,3 | 13,0 |

Сургалтын төлбөр төлсөн хэлбэрийг доорх зурагт үзүүлэв. Нийт суралцсан төгсөгчдийн 39.2 хувь нь өөрөө сургалтын төлбөрөө төлдөг, 30.8 хувь нь гэр бүлийнхнээрээ төлүүлдэг, 19.1 хувь нь байгууллага буюу ажил олгогчоор, 7.0 хувь нь буцалгүй тусламжид хамрагдаж үлдсэн 3.8 хувь нь үнэ төлбөргүй сургалтанд хамрагдсан гэж хариулсан.

Сургуулийн төрлөөр задлан харвал ИДС төгсөгчдийн 34.7 хувь нь гэр бүлийнхнээрээ төлбөрөө төлүүлдэг байхад MCYT төгсөгчдийн хувьд 24.9 хувь байна. Мөн MCYT төгсөгчдийн 23.4 хувь нь байгууллагаас сургалтын төлбөрөө төлүүлдэг байхад ИДС төгсөгчдийн 16.2 хувь нь л байгууллагаасаа төлбөрөө төлүүлдэг байна.

Зураг 18. Сургалтын төлбөр төлсөн байдал /сургуулийн төрлөөр/

ХЭМЖИХ НЭГЖ: ТОО




3.1 ДАХИН СУРАЛЦАГСАД

Нийт 7515 төгсөгч их дээд сургууль болон мэргэжил сургалтын төвд сүүлийн нэг жилд суралцсан байна. ИДС төгсөгчдийн 9.8 хувь, MCYT төгсөгчдийн 7.5 хувь нь дахин сурсан байна. Эдгээр төгсөгчдөөс дахин суралцаж байгаа шалтгааныг тодруулахад 44.1 хувь нь мэргэжил дээшлүүлэх, 26.8 хувь нь боловсролын түвшин, зэрэг ахиулах гэж хариулсан.

Зураг 19. Дахин суралцаж байгаа шалтгаан

Хэмжих нэгж: хувиар



Дахин суралцаж байгаа төгсөгчдийн 41.2 хувь нь өмнөх эзэмшсэн мэргэжлээсээ өөр мэргэжлээр сурч байна. ИДС төгсөгчдөөс дахин бакалаврын зэргийн сургалтанд хамрагдаж байгаа суралцагчдын 54.1 хувь нь өмнө эзэмшсэн мэргэжлээсээ огт өөр мэргэжлээр, 34.7 хувь нь их төсөөтэй мэргэжлээр суралцаж байна. Харин магистр, докторын зэргийн сургалтанд хамрагдагсадын 64.7 хувь нь ижил мэргэжлээр суралцаж байна. Дахин суралцаж байгаа MCYT төгсөгчдийн хувьд 41.0 хувь нь 2013 онд эзэмшсэн мэргэжлээсээ огт өөр мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт суралцаж байна.

Хүснэгт 17. Суралцаж байгаа мэргэжил болон өмнөх мэргэжлийн нийцэл
хэмжих нэгж: хувиар


| Ангилал | | Суралцаж байгаа /суралцсан/ сургалтын төрөл | | | | Нийт |
|-----------------|--------------------------------------|--|------------------------|---------------|----------------|-------|
| | | Огт өөр | Бага зэрэг төсөөтэй | Дунд зэрэг | Их төсөөтэй | |
| ИДС төгсөгч | Бакалаврын зэргийн сургалт | 54,1 | 6,7 | 4,5 | 34,7 | 100,0 |
| | Магистр, докторын зэргийн сургалт | 16,3 | 13,9 | 5,1 | 64,7 | 100,0 |
| MCYT төгсөгч | Мэргэжлийн анхан шатны боловсрол | 100,0 | 0,0 | 0,0 | 0,0 | 100,0 |
| | Тусгай мэргэжлийн дунд боловсрол | 100,0 | 0,0 | 0,0 | 0,0 | 100,0 |
| | Бакалаврын зэргийн сургалт | 41,0 | 4,7 | 17,6 | 36,7 | 100,0 |
| Нийт | | 41,2 | 8,2 | 7,5 | 43,1 | 100,0 |

Төгсөгчдийн сурч байгаа мэргэжлээр харвал MCYT төгсөгчид ИДС-д бакалаврын зэргээр бүх төрлийн инженер, нягтлан бодогч, хүний нөөц, эмч гэсэн мэргэжлээр түлхүү суралцаж байна.

Харин ИДС төгсөгч магистр болон түүнээс дээш зэргээр биохими, бизнесийн удирдлага, нягтлан бодогч, байгалийн нөөц гэх мэт чиглэлүүдээр суралцаж байна. ИДС болон MCYT төгсөгчдийн дахин суралцаж буй мэргэжлийг сонгосон шалтгаанаар нь хавсралт 3-5 -д үзүүлэв.

Сургалтанд хамрагдаад ямар өөрчлөлт гарсан болохыг сургуулийн төрлөөр харвал нийт суралцаж буй ИДС төгсөгчийн 31.0 хувь нь, MCYT төгсөгчдийн 40.8 хувь нь ажлын байрны шаардлагад нийцэхэд тус болсон гэсэн байна. MCYT төгсөгчдийн 20.2, ИДС төгсөгчдийн 24.2 хувь нь өөрийгөө танин мэдэж итгэлтэй болсон гэж үзсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Эндээс харахад төгсөгчид илүү сайн ажлын байртай болох гэж сурч байгаа харагдаж байна.

Зураг 20. Сургалтанд хамрагдсаны дараах өөрчлөлт /сургуулийн төрөл/
хэмжих нэгж: хувиар



БҮЛЭГ 4

АЖИЛ ХАЙХ ҮЙЛ ЯВЦ,
ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ




БҮЛЭГ 4. Ажил хайх үйл явц, цаашдын төлөвлөгөө

4.1 АЖИЛ ХАЙХ ЗОРИЛГО, ШАЛТГААН


Нийт 14779 төгсөгч ажилгүй байгаагаас 6630 нь ажил хийхэд бэлэн идэвхтэй ажил хайж байна. Үлдсэн 8149 төгсөгч ажил хийхэд бэлэн бус байна. Ажил идэвхтэй хайж байгаа төгсөгчдийн 2280 нь MCYT төгсөгч, 4350 нь ИДС төгсөгч байна.

Зураг 21. Ажил хайж байгаа төгсөгч /сургуулийн төрлөөр/



Ажилгүй байгаа төгсөгчдөөс сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн бус байсан шалтгааныг нь тодруулахад 35.5 хувь нь хүүхэд асарсан, 30.5 хувь нь суралцдаг, 21.1 хувь нь гэрийн ажилтай байсан гэж хариулсан.

Зураг 22. Ажилгүй байгаа төгсөгчдийн сүүлийн 7 хоногт ажил хийхэд бэлэн бус байсан шалтгаан хэмжих нэгж: хувь




4.2 АЖИЛ ХАЙХ ХЭЛБЭР, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ

Төгсөгчид хөдөлмөр зуучлалын байгууллагад бүртгүүлэх, танил талаараа дамжуулан ажил хайх нь нэмэгдсэн байна. Бодож байгаа ч тодорхой алхам хийхгүй буюу ажил хайхгүй байгаа төгсөгчид өмнөх онтой харьцуулахад 9.2 хувиар нэмэгдсэн ба зарын дагуу анкет бөглөх, ярилцлагад орох нь багассан байна. ИДС төгсөгчдийн 52.6 хувь нь, MCYT төгсөгчдийн 56.2 хувь нь зарын дагуу анкет бөглөх, ярилцлагад орохыг ажил хайх хэлбэрээрээ сонгож байна.

Зураг 23. Ажил хайх хэлбэр 2014, 2015 он /сургуулийн төрлөөр/

хэмжих нэгж: хувь



Ажлын байрны сонголт хийхдээ төгсөгчид хувийн зан чанарт нийцэх байдал, цалин хөлс, өсөж хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүй, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа зэрэгзүүлэлтүүдийг хамгийн түрүүнд хардаг байна. Харин ажлын чиг үүргийн хүндрэл, байгууллагын нэр хүнд, ажлын ачаалалд ач холбогдол өгдөггүй байна.

Хүснэгт 18. Ажлын байрны сонголт хийхдэд чухалчилдаг зүйлс /сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: 1-5 онооны дундаж

| Хүчин зүйл | Бүгд /дундаж/ | ИДС төгсөгч | MCYT төгсөгч |
|---------------------------------------|---------------|-------------|--------------|
| Нийт ажил хайж буй төгсөгч | 3,9 | 3,9 | 3,9 |
| Цалин | 4,1 | 4,1 | 4,1 |
| Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа | 4,2 | 4,1 | 4,2 |
| Байгууллагын нэр хүнд | 3,5 | 3,5 | 3,4 |
| Ажлын чиг үүргийн хүндрэл | 3,6 | 3,6 | 3,7 |
| Ажлын ачаалал | 3,5 | 3,6 | 3,4 |
| Өсөн хөгжих боломж | 4,3 | 4,2 | 4,3 |
| Ажил мэргэжлийн ирээдүй | 4,2 | 4,1 | 4,3 |
| Ажлын цаг | 3,9 | 3,9 | 4,0 |
| Ажлын орчин | 3,8 | 4,0 | 3,7 |
| Ажил, гэрийн хоорондын зайд | 3,2 | 3,2 | 3,2 |
| Хувийн зан чанарт нийцэх байдал | 4,8 | 4,7 | 4,8 |

Ажилд орохдоо ИДС, MCYT төгсөгчдийн хувьдадил хувийн зан чанарт нийцэх байдал, өсөн хөгжих боломж, ажил мэргэжлийн ирээдүй, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа зэргийг чухалчилдаг байна.

Энэ жилийн судалгаанд төгсөгчид зарын вэб сайтаас мэдээлэл авах, танил талаараа дамжуулан ажил хайх, гадаад төрхдөө анхаарах, хөдөлмөр зуучлалын байгууллагаар үйлчлүүлэх хэлбэрүүдээр ажил хайх хичээл зүтгэл хийж байна. Харин ажилд орохын тулд гадаад хэлний сургалт, дамжаанд явах болон TOEIC/TOEFL –ийн шалгалтанд бэлтгэж байгаа төгсөгчдийн хувь өсөхгүй байна.

Зураг 24. Ажил хайх хичээл, зүтгэл 2014, 2015 он

Хэмжих нэгж: хувиар



Төгсөгчид дунджаар 4.2 сар ажил хайж байгаа ба ИДС төгсөгч 5.0 сар, MCYT төгсөгч 3.4 сарын дундажтай байна. Ажилд орохоор ажил олгогчид хандсан дундаж тоо ИДС төгсөгчдийн хувьд 4.1, MCYT төгсөгчдийн хувьд 3.1 удаа байна.

Эдгээр ажил хайж байгаа төгсөгчдөөс ажил хайхад гарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулсан. Нийт төгсөгчдийн 14.9 хувь болон 17.4 хувь нь ажлын байрны мэдээллийн хомсдол, ажлын туршлага дутаж байна гэж тус тус хариулсан нь хамгийн гол бэрхшээл болж байна. Сургуулийн төрлөөр харвал ИДС болон MCYT төгсөгчид мөн адил эдгээр бэрхшээл хамгийн их байдаг гэж хариулсан байна.

Хүснэгт 19. Ажил хайх явцад гардаг хүндрэл бэрхшээл/ сургуулийн төрлөөр/

Хэмжих нэгж: хувиар

| Ангилал | | Ажлын байрны мэдээллийн хомсдол | Ажлын туршлага дутах | Нас, хүүсийн ялгарварлал | Ар гзрийн асуудал | Цалин хөлс | Ажлын орчин, ажлын цаг | Авшигал хээл хахууль | Хүнд суртал | Ажлын байрны хомсдол | АО танил тал хардаг | Бусад |
|------------------|------|---------------------------------|----------------------|--------------------------|-------------------|------------|------------------------|----------------------|-------------|----------------------|---------------------|------------|
| Сургуулийн төрөл | ИДС | 9,4 | 15,6 | 5,8 | 5,1 | 8,9 | 7,4 | 8,9 | 5,9 | 14,9 | 8,3 | 9,7 |
| | MCYT | 9,9 | 21,0 | 2,6 | 2,3 | 8,1 | 6,5 | 10,6 | 11,8 | 14,9 | 5,3 | 7,1 |
| Нийт | | 9,6 | 17,4 | 4,7 | 4,2 | 8,6 | 7,1 | 9,4 | 7,9 | 14,9 | 7,3 | 8,8 |

4.3 ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Судалгаанд хамрагдсан бүх төгсөгчдөөс 1 жилийн төлөвлөгөөг асуусан. Нийт төгсөгчдийн хувьд 27.7 хувь нь ажлаа үргэлжлүүлэн хийх, 16.3 хувь нь ажилд орох, 7.8 хувь нь дахин сурх гэж хариулсан байна. Харин ИДС төгсөгчдийн 28.6 хувь нь, MCYT төгсөгчдийн 26.4 хувь нь ажлаа үргэлжлүүлэн хийх гэж хариулсан ба эдгэр төгсөгчид тогтвортой ажиллах сонирхолтой байна. Мөн ажилд орох, дахин суралцах гэсэн төлөвлөгөөтэй байгаа төгсөгчид баагүй хувийг эзэлж байна.

Зураг 25. Төгсөгчдийн ойрын нэг жилийн төлөвлөгөө /сургуулийн төрлөөр/

хэмжих нэгж: хувиар



Төгсөгчдөөс ямар байгууллагад ажиллахыг тодруулахад төрийн захиргааны байгууллага 29.8 хувь нь, төрийн үйлчилгээний байгууллага гэж 21.9 хувь нь хариулсан.

Хүснэгт 20. Төгсөгчдийн ажиллахыг хүсч буй байгууллагын хэлбэр /сургуулийн төрлөөр/

хэмжих нэгж: хувиар

| Ангилал | Ажиллахыг хүсч буй байгууллага | | | | | | | Нийт | | |
|------------------|--------------------------------|---------------------------------|-----------------------------|----------------------|------------------------|-----------------------------------|-------|------|-----|-------|
| | Төрийн захиргааны байгууллага | Төрийн үйлчилгээний байгууллага | Төрийн өмчтэй аж ахуйн нэгж | Хувийн аж ахуйн нэгж | Олон улсын байгууллага | Өрхийн гишүүдийн хамтарсан бизнес | Бусад | | | |
| Сургуулийн төрөл | ИДС | 28,2 | 21,4 | 10,2 | 18,1 | 6,7 | 4,8 | 2,7 | 7,8 | 100,0 |
| | MCYT | 32,2 | 22,7 | 7,8 | 13,1 | 7,5 | 4,8 | 5,5 | 6,4 | 100,0 |

Төгсөгчдийн ажиллахыг хүсч байгаа байгууллагуудыг сонгох болсон шалтгаанаар нь сургуулийн төрлөөр дараах хүснэгтэд үзүүлэв.

MCYT төгсөгчдийн хувьд хувийн аж ахуйн нэгжид ажиллах сонирхолтой төгсөгчдийн сонгох болсон шалтгаан нь цалин сайтай, өсч хөгжих боломжтой гэж үзэж байхад, төрийн захиргааны байгууллагад ажиллах сонирхолтой төгсөгчид бусад салбартай харьцуулахад ажлын орчин нөхцөл, хангамж сайн, өсч хөгжих боломжтой гэж үзэж байна. Төрийн үйлчилгээний байгууллагад ажиллах сонирхолтой төгсөгчид мэргэжлийн онцлогоос шалтгаалсан гэж хамгийн ихээр харилусан байна.

Их дээд сургууль төгсөгчдийн хувьд олон улсын байгууллагад ажиллах сонирхолтой бөгөөд сонгох болсон шалтгаан нь өсч хөгжих боломжтой, цалин сайтай, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломжтой явдал юм байна.


Хүснэгт 21. Ажиллахыг хүсч буй байгууллага болон сонгосон шалтгаан /сургуулийн төрлөөр/

хэмжих нэгж: хувиар

| Нэр | | Цалин сайтай | Бусад салбартай харьцуулахад ажлын орчин нөхцөл, хангамж | Өсч хөгжих боломжтой | Байгууллагын нэр хүнд, ирээдүй, хамт олонгийн байх | Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломжтой | Ажлын тогтолцоог чаг, уян хатан нөхцөл | Мэргэжлийн онцлогоос | Тогтворт суурьшилтай ажиллах | Бусад |
|--------------|---------------------------------|--------------|--|----------------------|--|---|--|----------------------|------------------------------|-------|
| MCYT төгсөгч | Төрийн захиргааны байгууллага | 8,5 | 21,6 | 29,3 | 9,1 | 10,1 | 5,6 | 8,4 | 7,2 | 0,2 |
| | Төрийн үйлчилгээний байгууллага | 6,1 | 19,2 | 13,8 | 12,8 | 6,4 | 1,6 | 21,7 | 16,0 | 2,4 |
| | Хувийн аж ахуйн нэгж | 24,2 | 9,6 | 24,6 | 6,2 | 6,0 | 11,5 | 8,9 | 8,0 | 1,1 |
| ИДС төгсөгч | Төрийн захиргааны байгууллага | 7,4 | 16,2 | 28,2 | 7,1 | 6,6 | 11,0 | 8,8 | 14,1 | 0,6 |
| | Төрийн үйлчилгээний байгууллага | 7,2 | 21,7 | 18,3 | 7,9 | 3,1 | 9,7 | 21,5 | 9,6 | 1,0 |
| | Хувийн аж ахуйн нэгж | 21,6 | 5,6 | 19,0 | 10,2 | 2,0 | 14,7 | 12,0 | 14,7 | 0,1 |
